

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

2023 ОН



АГУУЛГА

I. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаасны
зах зээл

8

ХАА-н гаралтай
бараа, түүхий
эдийн зах зээл

14

Биржийн
бус зах зээл

15

Уул уурхайн
бүтээгдэхүүний
зах зээл

16

Ашигт
ажиллагаа

18

Тогтвортой
байдал

22

Бодлого
зохицуулалт

23

II. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах
зээлийн төлөв

28

Хүртээмжтэй
байдал

32

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

35

Ашигт
ажиллагаа

37

Тогтвортой
байдал

38

Бодлого
зохицуулалт

39

III. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зах
зээлийн төлөв

44

Хүртээмжтэй
байдал

49

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

52

Ашигт
ажиллагаа

55

Тогтвортой
байдал

57

Бодлого
зохицуулалт

61

IV. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Санхүүгийн зах
зээлийн төлөв

66

Хүртээмжтэй
байдал

68

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

72

Ашигт
ажиллагаа

76

Тогтвортой
байдал

78

Бодлого
зохицуулалт

80

V. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Санхүүгийн зах зээлийн төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Тогтвортой байдал
------------------------------	--------------------	------------------------	-----------------	-------------------

84

85

87

88

89

VI. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ

Салбарын төлөв	Ашигт ажиллагаа	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Бодлого зохицуулалт
----------------	-----------------	--------------------	------------------------	---------------------

92

95

96

97

100

VII. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

Салбарын төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Бодлого зохицуулалт
----------------	--------------------	------------------------	---------------------

104

105

106

107

VIII. СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Зохицуулалтын орчны төлөв	Сэндбоксад туршигдаж буй бүтээгдэхүүнүүд	Бодлого зохицуулалт
---------------------------	--	---------------------

108

110

116

IX. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Салбарын төлөв	Бодлого зохицуулалт
----------------	---------------------

120

122

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн Нэгдсэн Улс	ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
АХБ	Азийн хөгжлийн банк	ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага	ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ХОС	Хөрөнгө оруулалтын сан
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	МАPIX	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас	ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү	AFI	Alliance for Financial Inclusion /Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ	ATM	Automated teller machine /Автомат теллер машин/
МИК	Монголын ипотекийн корпораци	ESG	Environmental, Social, Governance /Байгаль орчин, нийгэм, засаглал/
МХЗХҮХ	Монголын хадгаламж, зээлийн хоршооны үндэсний холбоо	JICA	Japan International Cooperation Agency /Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага/
МХБ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	IAIS	International Association of Insurance Supervisors /Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо/
МҮЦБ	“Монголын үнэт цаасны бирж” ХК	IPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага	FPO	Follow up on public offering /Нэмэлт хувьцаа гаргах/
ТДЦА	Татварын дараах цэвэр ашиг	MSE	Mongolian stock exchange /Монголын хөрөнгийн бирж/
ТЗК	Тусгай зориулалтын компани	UNEP FI	Нэгдсэн үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүжилтийн санаачилга
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци		
УҮГ	Улсын үйлдвэрийн газар		
ҮХЭХБХСЗ	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал		
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал		
ҮЦК	Үнэт цаасны компани		
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв		
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж		
ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү		
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо		
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө		
ХК	Хувьцаат компани		

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	Зах зээлийн үнэлгээ 11,650.2 тэрбум төгрөг ЗЗҮ/ДНБ 17.8%	Нийт хөрөнгө 551.4 тэрбум төгрөг	ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ
ТОП-20 индекс 41,437.42	Арилжааны дүн 787.2 тэрбум төгрөг	Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж 398.7 тэрбум төгрөг	Даатгалын нөхөн төлбөр 120.9 тэрбум төгрөг
ҮЦК-ийн тоо 52	Хөрвөх чадвар 1.5%	Цэвэр ашиг 11.8 тэрбум төгрөг	Нөөц сан 268.9 тэрбум төгрөг
MSE A 17,574.53 MSE B 11,327.14	Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хэмжээ 7,541.4 тэрбум төгрөг	Гүнзгийрэлт 0.6%	Нягтрал 115,405 төгрөг Давхар даатгалын хураамжийн зардал 141.6 тэрбум төгрөг
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	Тусгай зөвшөөрөлтэй 529 ББСБ	90.4 % Зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй	Тусгай зөвшөөрөлтэй 191 ХЗХ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО
Нийт хөрөнгө 4.7 их наяд төгрөг	4.5 сая Харилцагч	Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 3.2%	72,521 гишүүн Нийт хадгаламж 215.2 тэрбум төгрөг
Нийт зээл 3.7 их наяд төгрөг	Нийт зээлдэгч 1.6 сая	Нийт хөрөнгө 306.5 тэрбум төгрөг	Цэвэр ашиг 10.9 тэрбум төгрөг
Зээлийн жигнэсэн дундаж хүү 3.3%	Нийт орлого 1,163.8 тэрбум төгрөг	Нийт хөрөнгө 2.3% Зээлийн жигнэсэн дундаж хүү	НИЙТ ЗЭЭЛ 209.1 тэрбум төгрөг Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 1.3%
ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ	ҮХЭХЗ-ын байгууллага 308	Иргэн 428	Хуулийн этгээд 52 ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ
Зуучлан худалдсан 2,287.5 тэрбум төгрөг	Зуучлан түрээслүүлсэн 178.1 тэрбум төгрөг	Үнэт металл худалдан авалт 433.8 тэрбум төгрөг	Үнэт металлын борлуулалт 461.1 тэрбум төгрөг



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ

11,650.2
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Дансны тоо
2,555,610



Хүртээмжтэй байдал

Нийт арилжааны дүн

787.2 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



ҮЦК-ийн хөрөнгө

331.5

тэрбум төгрөг

Улсад татан
төвлөрүүлсэн
татвар, НДШ
(ҮЦК, ХОМК)

6.8

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Төвлөрөл 3ЗҮ-ний

40.9 хувийг

Топ-10 ХК

Бодлого зохицуулалт



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ



Үнэт цаасны зах зээлд нийт **602** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна

Хувийн хөрөнгө оруулалтын сан (Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 5.3 дахь заалт)
38


Арилжаа эрхлэх 3	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн байгууллага 1	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагч 1
ХОМК 36	Тооцооны байгууллага 2 /1 давхардсан/	Кастодиан 3
Андеррайтерийн зөвшөөрөлтэй банк 2	Хөрөнгө итгэмжлэн удирдах 8	ХК 309
ҮЦК* 52	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх 1	ХАА түүхий эдийн брокер 10
ҮЦ33–д аудитын үйлчилгээ үзүүлэх 49 /8 давхардсан/	ҮЦ33–д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 24 /давхардсан/	ҮЦ33–д хуулийн үйлчилгээ үзүүлэх 43
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч 59 /ТЗК/	Хамтын хөрөнгө оруулалтын сан 6	Өөрийгөө зохицуулах байгууллага 2 /1 давхардсан/
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага 1 /давхардсан/	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч 3 /давхардсан/	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага 1

*ҮЦК–д брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.

Үнэт цаасны зах зээлийн арилжаа



- Нийт 787.2 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх оноос 32.3 хувиар, 2019 оноос 5.5 дахин өссөн үзүүлэлт юм.
- Нийт арилжааны 66.7 хувийг хувьцааны, 7.7 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн, 17.5 хувийг компанийн бондын, 8.1 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна.

Үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөг/



Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Зах зээлийн үнэлгээ өмнөх оноос 1.7 дахин өсөж 11,650.2 тэрбум төгрөгт хүрсэн бол хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хөрвөх чадвар 1.5 хувь байна.



ТОП 20 41,437.42

MSE A 17,574.53

MSE B 11,327.14

ТОП-20 ИНДЕКСТ БАГТАХ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ /ЗЗҮ-ЭЭР/



ҮНЭТ ЦААСНЫ ДАНСНЫ ТОО

- Шинээр үнэт цаасны 109,320 данс нээгдэж нийт дансны тоо 2,555,610-т, холболтын 59,700 данс нээгдэж нийт 590,455-т хүрлээ.



НИЙТ ДАНСНЫ ТОО
/ӨССӨН ДҮНГЭЭР/



2,555,610

ҮЦТХТ–Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС




ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

Монголын хөрөнгийн бирж, Улаанбаатар үнэт цаасны бирж дээр идэвхтэй арилжаа явуулдаг 171 ХК–ийн төвлөрлийг хувьцааны 5–аас дээш болон доош хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн хувиар тооцож доорх хүснэгтэд харуулав.



АРИЛЖААНЫ БҮТЭЦ /ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДААР/

- Дотоодын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 49.5 хувийг, дотоодын ААН–ийн хийсэн арилжааны гүйлгээ 48.3 хувийг, гадаадын ААН–ийн хийсэн арилжааны гүйлгээ 1.3 хувийг, гадаадын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 0.9 хувийг тус тус эзэлж байна.




ХУВЬЦААНЫ ӨМЧИЙН БҮТЭЦ

- Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 309 ХК–ийн өмчийн бүтцийг задлан харвал нийт ХК–ийн 89.3 хувь нь хувийн өмчит, 6.8 хувь нь төрийн өмчит, 3.9 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байна.


ҮЦК БАЙРШИЛ

- 52 ҮЦК-аас 51 нь Улаанбаатарт, 1 нь Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа эрхэлж байна.



ҮЦК-ИЙН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАЙРШИЛ

- ҮЦК-ийн 38 салбар, төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж буйгаас 36 нь орон нутагт, 2 нь Улаанбаатар хотод байршиж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Нийт хувьцааны арилжаа 524.8 тэрбум төгрөгт хүрсэн нь 2019 онтой харьцуулахад 3.9 дахин, өмнөх оноос 1.5 дахин өсжээ.




ШИНЭЭР ГАРГАСАН ХУВЬЦАА /IPO/

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	Олон нийтээс татан төвлөрүүлсэн дүн /тэрбум төгрөг/
"Газар шим үйлдвэр" ХК	2023.01.25	10.5
"Хаан банк" ХК	2022.12.09	183.4
"Худалдаа хөгжлийн банк" ХК	2023.05.12	83.5
"Хас банк" ХК	2023.05.12	35.7
"Монложистикс Холдинг" ХК	2023.06.13	11.0
"Мост Финтек" ХХК	2023.10.25	5.8
"Инновэйшн Инвестмент" ХХК	2023.11.08	8.3
НИЙТ		338.2

КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

- Компанийн бондын арилжаа 138.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.0 хувиар өсчээ.




ШИНЭЭР ГАРГАСАН КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	Өрийн хэрэгслийн дүн /тэрбум төгрөг/
"Сэндли ББСБ" ХК	2023.01.13	8.5
"Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК	2023.05.12	8.0
"Хаан банк" ХК /ногоон бонд/	2023.06.13	17.0
"Ашид капитал ББСБ" ХХК	2023.06.23	20.0
"Лэндмн ББСБ" ХК	2023.08.11	9.0
"Инвекор ББСБ" ХК, Инвекор бонд-2.0 /Транч-3,4,5/	2023.08.25	30.0
"Ашид капитал ББСБ" ХХК	2023.10.02	15.0
НИЙТ		107.5

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа 63.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 38.8 хувиар буурчээ.




ШИНЭЭР ГАРГАСАН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	ХБҮЦ-ны дүн /тэрбум төгрөг/
"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК	2023.03.31	9.0
"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК	2023.06.02	20.0
"Омни ассет ТЗК" ХХК	2023.11.08	6.0
"Бэрс Эй Би Эс лоялти ТЗК" ХХК	2023.12.22	15.0
НИЙТ		50.0

Бодлогын баримт бичиг	Үнэт цаас гаргагч	Бүртгэсэн огноо	ХБҮЦ-ны дүн /тэрбум төгрөг/
УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийн хүрээнд	"ҮЦСК актив тав ТЗК" ХХК	2023.05.12	43.3
	"ҮЦСК актив зургаа ТЗК" ХХК	2023.11.08	40.0
"Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох" хөтөлбөрийн хүрээнд	"МИК актив гучин гурав" ХХК	2023.06.13	265.1
	"МИК актив гучин дөрөв ТЗК"	2023.11.08	405.3
НИЙТ			753.7

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АРИЛЖАА

- Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа 60.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 4.5 дахин өсжээ.




ШИНЭЭР ГАРГАСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ДҮН /тэрбум төгрөг/
"Ашид арвижих хамтын ХОС" ХХК	2023.01.13	1.01
"Инвескор Глобал Кью хамтын биржээр арилжаалагддаг ХОС" ХХК	2023.11.17	0.4
НИЙТ		1.4

ХӨДӨӨ, АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ




ХААБ–ээр нийт 11 төрлийн, 968.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оноос 141.7 тэрбум төгрөгөөр буюу 12.8 хувиар буурсан.



ХААБ–ийн нийт арилжааны 0.1 хувийг бүрдүүлж буй бараа бүтээгдэхүүнд хонины завод ноос 81.4 сая төгрөг, тэмээний завод ноос 8.4 сая төгрөг, тэмээний очёс 18.9 сая төгрөг, бодын хөөвөр 206.0 сая төгрөг, боловсруулаагүй үхрийн шир 6.6 сая, арьс шир 6.6 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

ХАА–Н БРОКЕРЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ


- 10 ХАА–н брокер үйл ажиллагаа явуулж байгаагийн 7 нь Улаанбаатар хотод, 3 нь орон нутагт байршиж байна.





БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛ

Биржийн бус зах зээлд нийт 63 үнэт цаас гаргагчийн, 195 транч өрийн хэрэгсэл бүртгэгдлээ. Үүнээс 1,065.7 тэрбум төгрөгийн өрийн хэрэгсэл бүртгэгдэж 829.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Мөн 59 сая ам.долларын өрийн хэрэгсэл бүртгэгдэж 33.5 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна.



Ингэснээр биржийн бус зах зээлийн арилжаа 2021 оны 9 дүгээр сард анхны өрийн хэрэгслээ бүртгэж үйл ажиллагаагаа эхэлснээс хойш төгрөгөөр 2,441.4 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийг бүртгэж, 1,743.1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Мөн доллароор 71 сая ам.долларын өрийн хэрэгсэл бүртгэж 45.5 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлжээ.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 299 удаагийн 7,541.4 тэрбум төгрөгийн арилжаа явагдлаа. Үүнээс: 204 удаагийн арилжаагаар 14.9 сая тонн нүүрсийг 7,345.2 тэрбум төгрөгөөр, 95 удаагийн арилжаагаар 677.4 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 196.2 тэрбум төгрөгөөр тус тус арилжаагдсан.




2,234 багц буюу
14,937,600 тонн нүүрс
7,345.2 тэрбум төгрөг




212 багц буюу
677,450 тонн төмрийн хүдэр,
баяжмал **196.2** тэрбум төгрөг

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУДАЛДАГЧ ТАЛ /ХЭЛЦЛИЙН ТООГООР/



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУДАЛДАН АВЧ БАЙГАА УЛСУУД /ХЭЛЦЛИЙН ТООГООР/



НҮҮРСНИЙ АРИЛЖАА

Баяжуулсан
коксжих нүүрс

230 багц буюу
1,472,000 тонн
950.0 тэрбум төгрөг

Баяжуулсан сул
коксжих нүүрс

22 багц буюу
140,800 тонн
68.1 тэрбум төгрөг

1/3 коксжих
нүүрс

459 багц буюу
2,937,600 тонн
1,074.9 тэрбум төгрөг

Дэгдэмхий бодис дунд,
коксжих нүүрс

1,377 багц буюу
8,812,800 тонн
4,798.8 тэрбум төгрөг

Хатуу коксжих
нүүрс

35 багц буюу
224,000 тонн
141.1 тэрбум төгрөг

Эрчим хүчний
нүүрс

168 багц буюу
1,075,200 тонн
238.5 тэрбум төгрөг

Дэгдэмхий бодис дундаас
их, хийн нүүрс

17 багц буюу
108,800 тонн
35.8 тэрбум төгрөг

Баяжуулсан дунд зэрэг
үнстэй хагас хатуу
коксжих нүүрс

24 багц буюу
153,600 тонн
36.6 тэрбум төгрөг

Чийг багатай
хүрэн нүүрс

2 багц буюу
12,800 тонн
1.4 тэрбум төгрөг

ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖАА

Fe-52%-ийн агууламжтай
төмрийн хүдэр



70 багц буюу 228,750 тонн
61.5 тэрбум төгрөг

Fe-58%-ийн агууламжтай
төмрийн баяжмал




72 багц буюу 238,700 тонн
63.4 тэрбум төгрөг

Fe-65%-ийн агууламжтай
төмрийн баяжмал



70 багц буюу 210,000 тонн
71.3 тэрбум төгрөг


АШИГТ АЖИЛЛАГАА



ҮЦК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА


- ҮЦК-уудын нийт хөрөнгө 331.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 75.1 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх онтой харьцуулахад орлого 8.3 тэрбум төгрөгөөр, зарлага 8.0 тэрбум төгрөгөөр өсөж 16.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

● Брокерын үйл ажиллагааны орлого	22.2%
● Дилерийн үйл ажиллагааны орлого	8.6%
● Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	36.9%
● Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны орлого	7.4%
● Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	4.7%
● Бусад үйл ажиллагааны орлого	0.7%
● Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого	3.3%
● Хүүний орлого	13.2%
● Ногдол ашгийн орлого	1.5%
● Бусад орлого	0.4%
● Бусад ашиг	1.1%



ҮЦК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ

● Борлуулалтын маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	83.1%
● Санхүүгийн зардал	9.9%
● Бусад зардал	1.8%
● Орлогын татварын зардал	4.7%
● Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.5%



3.4

тэрбум төгрөг

Нийгмийн даатгалын шимтгэл

2.1

тэрбум төгрөг

Орлогын албан татвар


0.2

тэрбум төгрөг

Хувь хүний орлогын албан татвар

- Үнэт цаасны компаниуд НДШ-д 3.4 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.2 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 2.1 тэрбум төгрөгийг тус тус төлж, нийт улсын төсөвт 5.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.


ХОМК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




ХОМК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХОМК-уудын нийт хөрөнгө 74.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 8.0 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх онтой харьцуулахад орлого 2.8 тэрбум төгрөгөөр, зарлага 0.8 тэрбум төгрөгөөр өсөж 0.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.

ХОМК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ




ХОМК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ





- Хөрөнгө оруулалт менежментийн компаниуд НДШ-д 0.8 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.04 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 0.28 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт 1.12 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.


ХААБ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ХААБ-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХААБ-уудын нийт хөрөнгө 5.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 8.5 хувиар буурсан үзүүлэлт юм.
- Өмнөх онтой харьцуулахад орлого 1.4 тэрбум төгрөгөөр өсөж зарлага 0.1 тэрбум төгрөгөөр буурж 1.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

КАСТОДИОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




КАСТОДИОНЫ АШИГТ АЖИЛЛАГАА


- Кастодиан банкны нийт хөрөнгө 1,357.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 27.1 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх онтой харьцуулахад орлого 0.2 тэрбум төгрөгөөр зарлага 0.1 тэрбум төгрөгөөр өсөж 0.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

КАСТОДИАНЫ ХАРИЛЦАГЧДЫН БҮТЭЦ

- Кастодиан банкны нийт харилцагчдын 97.4 хувийг дотоодын иргэн, 2.2 хувийг дотоодын ААН, 0.2 хувийг гадаадын иргэн, 0.2 хувийг гадаадын ААН тус тус эзэлж байна.




- Кастодиан банканд хадгалагдаж буй хөрөнгийг ангилан үзвэл 98.8 хувийг харилцагчдын эзэмшиж буй үнэт цаас, 0.8 хувийг ХБҮЦ, 0.1 хувийг мөнгөн хөрөнгө, үүсмэл санхүүгийн хэрэгсэл /гэрээнүүд/ 0.2 хувийг, үл хөдлөх эд хөрөнгө 0.1 хувийг тус тус эзэлж байна.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Арилжаа эрхлэх байгууллагын ТОП-20 индексийн сагсанд орсон хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээгээр хамгийн өндөр 10 ХК нийт зах зээлийн үнэлгээний 40.9 хувийг, хамгийн өндөр үнэлгээтэй 5 ХК 33.6 хувийг бүрдүүлж байна.




ҮЦК-УУДЫН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ

- 51 ҮЦК-ийн 92.2 хувь буюу 47 ҮЦК-ийн эргэлтийн хөрөнгийн харьцаа 1-ээс их харин үлдсэн 7.8 хувь буюу 4 ҮЦК нь 1-ээс бага байна.
- Дээрх 51 компанийн өрийн харьцаа бүгд 1-ээс бага байна.



ХОМК-ДЫН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ

- ХОМК-ийн 63.9 хувь буюу 32 ХОМК-ийн эргэлтийн харьцаа 1-ээс их, үлдсэн 36.1 хувь болох 36 ХОМК нь 1-ээс бага эргэлтийн хөрөнгийн харьцаатай байна.
- Харин өрийн харьцаа 1-ээс бага нийт компанийн 77.8 хувь буюу 28 ХОМК, 1-ээс их нийт компанийн 22.2 хувь буюу 8 ХОМК байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хууль эрх зүйн орчны шинэчлэл

- Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хариуцан боловсруулахаар тусгасан. Энэ хүрээнд Сангийн сайдын 2021 оны 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчин шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс боловсруулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газар хэлэлцэж, Улсын Их Хуралд 2023 оны 12 дугаар сард өргөн мэдүүлсэн.

Бизнесийн үнэлгээ хийх журам, аргачлалын шинэчлэл

- Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сард Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан “Бизнесийн үнэлгээ хийх аргачлал”-ыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн батлах шаардлага үүссэн. Энэ хүрээнд Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А/144/348 дугаар хамтарсан тушаалаар “Бизнесийн үнэлгээ хийх журам” болон “Бизнесийн үнэлгээ хийх аргачлал”-ыг тус тус баталсан.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зохицуулалт

- Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сард Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг баталсан. Иймд дараах 3 журам болон хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А-164/386, А-165/385 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
 - Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, хэмжээг тогтоох, хэлцэл хийхэд баримтлах журам;
 - Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам;
 - Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам;
 - Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас олгох зээлд баримтлах шаардлага.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дэмжих хүрээнд

- Хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын орчныг сайжруулах, зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд, хамтын хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагаанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 464 дүгээр тогтоолоор “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын хамтын сангийн активт тавих шаардлагыг хөнгөвчилсөн өөрчлөлтийг баталсан.

Банкны салбарын реформ:

- Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар системд нөлөө бүхий банкууд компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулж, хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд хувьцаа гаргах замаар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болох, мөн хувьцаа эзэмшлийн төвлөлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангах үүргийг тус тус хүлээсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс банкны системд нөлөө бүхий банкуудын нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болох хуулийн шаардлагыг хангуулах хүрээнд зохицуулалтын орчныг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэхийн зэрэгцээ нийтэд санал болгон үнэт цаас гаргахтай холбогдуулан зөвлөгөө мэдээлэл өгөх, зохицуулалтын бодлогоор тухай бүр дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Үүний үр дүнд “Богд банк” ХК болон системд нөлөө бүхий 5 банк болох “Төрийн банк” ХК, “Голомт банк” ХК, “ХААН банк” ХК, “Худалдаа Хөгжлийн банк” ХК, “Хас банк” ХК-ийн IPO хийх ажиллагаа амжилттай хэрэгжсэн. Нийт давтагдсан тоогоор 72 мянга гаруй хөрөнгө оруулагчдаас 478.54 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлснээс гадна зах зээлийн үнэлгээг 5.86 их наяд төгрөгөөр нэмэгдсэн.



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖ

Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сард Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан. Үүнтэй холбогдуулж Санхүүгийн зохицуулах хороо дараах журмуудыг баталж, захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам;
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа төлбөр, тооцоо хийх ерөнхий журам;
- Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам;
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд зааснаар уул уурхайн бүтээгдэхүүний бирж нь үйл ажиллагаандаа дагаж мөрдүүлэхээр 11 харилцааг зохицуулсан журмуудыг баталж, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөр үйл ажиллагаандаа дагаж мөрдөхөөр заасны дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас баталсан нэр бүхий 7 журмыг, Санхүүгийн зохицуулах хорооны 387, 458, 465 дугаар тогтоолоор мөрдүүлэхийг зөвшөөрсөн.

Түүнчлэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд зааснаар биржийн үйлчилгээний хураамжийг биржээс ирүүлсэн санал, судалгааг харгалзан Санхүүгийн зохицуулах хороо тогтоохоор заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 386, 793 дугаар тогтоолоор “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйлчилгээний хураамж”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйлчилгээний төлбөр, хураамж” —ыг тус тус баталсан.

Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор уул уурхайн бүтээгдэхүүний биржээр боловсруулаагүй нүүрс, баяжуулсан нүүрс, төмөр болон хайлуур жоншны хүдэр, баяжмалыг арилжаалахаар шийдвэрлэсэн ба дээрх бүтээгдэхүүнүүд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар амжилттай арилжаалагдаж байна. Тухайлбал 2023 онд тус биржээр нийт 15.6 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 7.54 их наяд төгрөгөөр арилжаалжээ.

Уул уурхайн бүтээгдэхүүн биржээр дамжуулан арилжаалагдаж эхэлснээр арилжаа олон нийтэд нээлттэй, шударга, ил тод зохион байгуулагдаж, бүтээгдэхүүн үнийн өсөлттэй арилжаалагдах, экспортыг нэгдсэн бодлогоор хангах зэрэг олон давуу тал бий болоод байна.



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө

551.4 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **16.1%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Даатгалын нягтрал

115,405 төгрөг

Нягтралын өсөлт
31.4%



Хүртээмжтэй байдал

Зуучилсан даатгалын
болон давхар даатгалын
нийт хураамж

100.6 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг
11.8
тэрбум төгрөг

Улсад татан
төвлөрүүлсэн
татвар, НДШ **15.2**

Тогтвортой байдал



Давхар даатгалд
төлсөн хураамж
36.1%

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр 337 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 2,416 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж байна.



ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

- Даатгалын гүнзгийрэлт 0.60 хувьд хүрч өнгөрсөн онтой харьцуулахад 0.03 пунктээр буурсан.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 16.1 хувиар өсөж 551.4 тэрбум төгрөгт хүрсэн бол 2019 онтой харьцуулахад 50.7 хувиар өсжээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ бусад даатгалын төрөлтэй харьцуулахад өмнөх оноос 17.8 хувиар өсөж 469.0 тэрбум төгрөгт хүрснээр салбарын нийт хөрөнгийн 85.0 хувийг бүрдүүлж байна.
- Урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 0.6 хувиар өсөж 16.4 тэрбум төгрөгт хүрч, салбарын 3.0 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компанийн нийт хөрөнгө өмнөх оноос 9.3 хувиар өсөж, 65.9 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 12.0 хувийг эзэлж байна.


ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БҮТЭЦ /НИЙТ ХӨРӨНГӨӨР/

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл 28.4 тэрбум төгрөг буюу 5.2 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, 333.5 тэрбум төгрөг буюу 60.6 хувийг хөрөнгө оруулалт, 43.3 тэрбум төгрөг буюу 7.9 хувийг үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр дүн/, 145.0 тэрбум төгрөг буюу 26.3 хувийг бусад хөрөнгө тус тус бүрдүүлж байна.



Даатгалын компаниудыг нийт хөрөнгөд эзэлж буй хувиар нь авч үзвэл 9 хувиас дээш хувийг 2 даатгалын, 6–9 хувийг 6 даатгалын, 3–6 хувийг 4 даатгалын, 3 хувиас доош хувийг 6 даатгалын компани тус тус бүрдүүлж байна.


Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь




ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨЛТИЙН ТАРХАЛТ

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 2022 оны байдлаар 13.0 хувь байсан бол тайлант онд 15.6 хувьтай байна. Харин хөрөнгийн өсөлтөөр бүлэглэвэл 30-аас дээш өсөлттэй 3, 20-30 хувийн өсөлттэй 4, 10-20 хувийн өсөлттэй 2, 0-10 хувийн өсөлттэй 6, хөрөнгийн хэмжээ буурсан 3 даатгалын компани тус тус байна.

2021-2022 / 2022-2023



- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж



НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 392.0 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ.

Үүнээс: ердийн даатгалын компаниуд 388.9 тэрбум төгрөг буюу 99.2 хувь, урт хугацааны даатгалын компаниуд 3.1 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг бүрдүүлжээ.


- Нийт хураамжийг өмнөх онтой харьцуулахад 30.4 хувиар, 2019 онтой харьцуулахад 99.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ДАВХАР ДААТГАЛД ТӨЛСӨН ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 141.6 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид төлсөн. Үүний 6.7 тэрбум төгрөг буюу 4.8 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.


НӨХӨН ТӨЛБӨР, ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 120.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 28.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин 2019 онтой харьцуулахад 84.6 хувиар өсжээ. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.3 хувийг бүрдүүлжээ.
- Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн дүн 84.1 хувиар өсөж 16.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.



НӨӨЦ САН

- Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 24.0 хувиар өсөж 268.9 тэрбум төгрөгт хүрсэн.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 28.6 хувиар өсөж 234.4 тэрбум төгрөгт хүрсэн бол, урт хугацааны даатгалын компаниудын нөөц сан 9.2 хувиар өсөж 3.1 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 1.2 хувиар буурч 31.4 тэрбум төгрөг болов.




268.9
Тэрбум төгрөг
2023

216.9
Тэрбум төгрөг
2022

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ДААТГАЛЫН НЯГТРАЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцоолох боломжгүй юм.



- Даатгалын нягтрал 2023 онд 115,405 төгрөг болж 2022 онтой харьцуулахад 31.4 хувиар, 2019 онтой харьцуулахад 90.1 хувиар тус тус өссөн байна.
- Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 31.5 хувиар өсөж 111,420 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 16.5 хувиар өсөж 926 төгрөгт хүрсэн байна.

Жич: Монгол Улсын 2023.12.31-ны байдлаарх нийт хүн амын тоог Үндэсний статистикийн хорооноос авсан болно.

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

Нийт 1,546,378 даатгалын гэрээ байгуулагдсан байна. Үүний 82.8 хувь буюу 1,279,721 хувь хүнтэй, 17.2 хувь буюу 266,657 нь хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ болно.

ХУВЬ ХҮН **1,279,721**


ХУУЛИЙН
ЭТГЭЭД **266,657**



САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ

Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Орон нутагт даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлгээний нийт 1,799 төлөөлөгч, 444 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.

ДААТГАЛЫН КОМПАНИ, ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧДИЙН САЛБАР /БАЙРШЛААР/




ТӨЛӨӨЛӨГЧИД




САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ

Улаанбаатар хот

- Улаанбаатар хотод нийт 302 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулснаас даатгалын компанийн 43, даатгалын зуучлагчийн 215, хохирол үнэлэгчийн 44 салбар байна. Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 92.7 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрчээ.
- Улаанбаатар хотод нийт 617 төлөөлөгч үйл ажиллагаа явуулав.
- Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй даатгалын компанийн төлөөлөгчийн газар 12 байгаагаас БНХАУ–д нэг байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



- Ердийн болон урт хугацааны даатгалын 23 хэлбэрээс “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-аас бусад нь сайн дурын даатгалын хэлбэр юм.
- Давхардсан тоогоор даатгалын бүтээгдэхүүнийг 2022 онтой харьцуулахад 26 бүтээгдэхүүнээр өсөж 713 болов. Энэ нь 2019 онтой харьцуулахад 121 бүтээгдэхүүнээр нэмэгдсэн байгаа юм.

Ердийн даатгалын нийт хураамж




Ердийн даатгалын нөхөн төлбөр




АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамж өмнөх онтой харьцуулахад 14.4 хувиар өсөж 46.9 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт даатгалын хураамжийн орлогын 12.0 хувийг эзэлж байна.
- Нөхөн төлбөр нь өмнөх онтой харьцуулахад 11.6 хувийн өсөлттэй байна. Тайлант онд 35.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 29.5 хувийг бүрдүүлжээ.



ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД

Даатгалын зуучлагчдын төвлөрүүлсэн даатгалын болон давхар даатгалын хураамж 100.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өмнөх онд 15.2 тэрбум төгрөг байснаас 27.6 хувиар өсөж 19.4 тэрбум төгрөгт хүрэв.



- Хүрэнгийн
- Жолоочийн хариуцлагын албан журмын
- Авто тээврийн хэрэгслийн
- Зээлийн
- Мал амьтдын
- Хариуцлагын
- Эрүүл мэндийн
- Бусад

ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД

Даатгалын хохирол үнэлэгч компаниуд 44,452 хохирлыг 83.4 тэрбум төгрөгөөр үнэлэв. Даатгалын хохирол үнэлгээний орлого өмнөх онтой харьцуулахад 41.4 хувиар өсөж 4.3 тэрбум төгрөгт хүрлээ.




- Хүрэнгийн даатгал
- Авто тээврийн хэрэгслийн даатгал
- Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
- Бусад



АШИГТ АЖИЛЛАГАА



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Даатгалын компаниудын цэвэр ашиг 2022 оны онтой харьцуулахад 36.0 хувиар буурч 11.8 тэрбум төгрөгт хүрсэн.
- Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 10, 50 хувь хүртэлх өсөлттэй 5, 50–100 хувийн өсөлттэй 1, 100 хувиас дээш өсөлттэй 2 даатгалын компани байна.



ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хохирол нөхөлтийн харьцаа 2022 онтой харьцуулахад 1.7 пунктээр өсөж 55.7 хувь;
- Зардлын харьцаа 1.5 пунктээр буурч 60.0 хувь;
- Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа 3.1 пунктээр буурч 3.0 хувьд тус тус хүрлээ.



АШИГТ АЖИЛЛАГААНЫ КОЭФИЦИЕНТ

- Нийт хөрөнгийн өгөөж 1.9 пунктээр буурч 2.1 хувьд хүрсэн бол өөрийн хөрөнгийн өгөөж 3.8 пунктээр буурч 5.2 хувьд хүрлээ.

- Даатгалын компаниуд нь 9.0 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд, 2.5 тэрбум төгрөгийг хувь хүний орлогын албан татварт, 3.7 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт төлж, нийт 15.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

- Монгол Улсын даатгалын зах зээлийн тулгамдаж буй асуудлын нэг нь валютын ханшийн эрсдэл юм.
- Даатгалын компаниудын дийлэнх нь гадаад улсад давхар даатгуулдаг бөгөөд сүүлийн гурван жилийн хугацаанд 1 жилд дунджаар 83.7 орчим тэрбум төгрөгийг гадаад улсруу шилжүүлжээ.
- Даатгалын компаниудын гадаад улсад төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн зардал даатгалын нийт хураамжийн 36.1 хувьтай тэнцэж байна.


36.1%

Давхар даатгалын
хураамжийн нийт
хураамжид
эзлэх хувь

- Даатгалын компаниуд нийт хөрөнгийн 60.6 хувийг хөрөнгө оруулалтад байршуулснаас 70.9 хувь нь хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэртэй байна.
- Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасны хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд нийт 34.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олжээ.


Хөрөнгө
оруулалтын
дүн
60.6%

Давхар даатгалын хураамж



Жич: 1. Давхар даатгалын хураамжийг өссөн дүнгээр тооцсон.
2. Монголбанкны 2023.12.31-ны өдрийн ам.долларын ханш.

Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх чиглэлээр ажиллаж байна.
- Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах хүрээнд Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос байгуулсан дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллана.
- Гамшгийн эрсдэлийн даатгалын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Гамшгийн эрсдэлийн даатгалын хуулийн төслийг эцэслэн боловсруулахаар Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллана.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 559 дүгээр тогтоолоор “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан. Энэхүү журам хэрэгжиж эхэлснээр даатгагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо боловсронгуй, нээлттэй, ил тод болохын зэрэгцээ даатгалын зах зээлийн эрсдэлийг урьдчилан таних, түүнээс сэргийлэх систем нэвтрэх, улмаар салбарын засаглал сайжирч, тогтвортой байдал хангагдах, хөрөнгө оруулагч, даатгуулагчдын даатгалд итгэх итгэл нэмэгдэх чухал ач холбогдолтой.
- “Даатгалын багц дүрэм”-ийн 1, 3, 4, 11, 13, 19 дүгээр хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт орууллаа. Дээрх нэмэлт, өөрчлөлтөд даатгалын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд тавигдах шаардлага, давхар даатгагчийн нөөц сангийн бүрдүүлэлт, тайлагналтай холбоотой зохицуулалтаас гадна даатгалын байгууллагуудын цахим даатгал, жендер болон бусад холбогдох мэдээллийг хүлээн авахтай холбоотой санхүүгийн нэмэлт тайлангийн маягтуудыг багтаасан.
- Салбар бүрийн эрсдэлийн онцлогоос шалтгаалан заавал шилжүүлэх эрсдэлийг тодорхой болгож, заавал даатгалын нэгдсэн зохицуулалтын орчныг бүрдүүлэхээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооноос Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дэд ажлын хэсэгт орж ажиллаж байна.
- Даатгалын салбарт мөрдөгдөж буй татварын хууль, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал боловсруулж, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.
- Ипотекийн зээлдэгчийн даатгалтай холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, даатгуулагчдад хэрэгцээтэй даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх бодлого, зохицуулалтын шийдвэр гаргах зорилгоор “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Жижиг, дунд бизнес эрхлэгчид (ЖДҮ)-ийн цаг агаарын эрс тэс уур амьсгалтай холбоотой эрсдэлийг даатгалаар дамжуулан бууруулах, мэдлэг, чадварыг сайжруулах зорилгоор Германы хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ болон “Монре даатгал” ХХК хамтран хэрэгжүүлж буй “ЖДҮ-г блокчейн ашиглан даатгах нь” төслийн хүрээнд даатгалын салбарын актуарч нарт зориулсан сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 02-ноос 06-ны өдрүүдэд зохион байгуулсан.
- Дээрх төслийн хүрээнд Английн Даатгалын итгэмжлэгдсэн институт /Chartered Insurance Institute/-ээс зохион байгуулдаг хөтөлбөрийн дагуу 5 хичээлийн хүрээнд Даатгалын газрын нийт албан хаагчдыг чадавхжуулав.
- Солонгосын санхүүгийн үйлчилгээний хороотой хамтын ажиллагааны хүрээнд туршлага хуваалцаж, санал солилцов.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 187, 188 дугаар тушаалаар олон нийтийн даатгалын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Санхүүгийн Зохицуулах Хороо болон даатгалын салбарын оролцогч нарын төлөөлөл бүхий 2 ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу холбогдох уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг тухай бүр зохион байгуулж ажилласан.
- Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай болон Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах хүрээнд Сангийн яамтай хамтран даатгалын салбарын нийт оролцогчдыг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан.
- Даатгалын багц дүрмийн 2 дугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын төслийг шинэчлэн сайжруулах хүрээнд даатгалын салбарын оролцогчдоос санал авахаар холбогдох уулзалтуудыг зохион байгуулсан.
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар даатгалын салбар болон даатгалын зуучлагч банкныг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө

4.7

их наяд төгрөг

Хөрөнгийн өсөлт

32.5%



Санхүүгийн зах зээлийн төлөв

Харилцагч

4.5 сая

Дундаж зээлийн хэмжээ

2.3 сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Зээлийн ББСБ

90.4%

Зөвхөн гадаад валютын
арилжааны ББСБ

9.1%



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

1,163.8

тэрбум төгрөг

Улсад татан
төвлөрүүлсэн
татвар, НДШ

111.4

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Z индекс

21.2

Чанаргүй зээлийн нийт
зээлд эзлэх хувь

7.0%

Бөдлого зохицуулалт



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 529 банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ үйл ажиллагаа явуулав. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 3.1 хувиар өссөн, 2019 онтой харьцуулбал 1.7 хувиар буурсан байна.






Нийт ББСБ –ын 4.5 хувь нь буюу 24 ББСБ нь гадаадын хөрөнгө оруулалтаар, 95.5 хувь буюу 505 ББСБ нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



ББСБ-УУДЫН ХӨРӨНГӨ

ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 4.7 их наяд төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 1,145.2 тэрбум төгрөгөөр буюу 32.5 хувиар, 2019 онтой харьцуулбал 2.9 их наяд төгрөгөөр буюу 2.7 дахин өсжээ.



ББСБ-уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/


Нийт хөрөнгийн дүн	4,672.2	100.0%	
Эргэлтийн хөрөнгө	4,526.2	96.9%	
Мөнгөн хөрөнгө	652.9	14.0%	
Зээл /цэврээр/	3,475.9	74.4%	
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	50.7	1.1%	
Факторингийн тооцооны авлага /цэврээр/	14.7	0.3%	
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	25.9	0.5%	
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	4.0	0.1%	
Бусад хөрөнгө	302.1	6.5%	
Эргэлтийн бус хөрөнгө	146.1	3.1%	

ББСБ-уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	4,672.2	100.0%	
Өр төлбөр	1,926.9	41.3%	
Санхүүгийн эх үүсвэр	651.9	14.0%	
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	586.4	12.5%	
Бусад эх үүсвэр	47.0	1.0%	
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	316.3	6.8%	
Төслийн зээлийн санхүүжилт	23.8	0.5%	
Бусад өр төлбөр	301.5	6.5%	
Эздийн өмч	2,745.3	58.7%	
Хувьцаат капитал	1,498.0	32.1%	
Бусад өмч	62.5	1.3%	
Сангууд	1.6	0.0%	
Хуримтлагдсан ашиг/ алдагдал	1,107.2	23.7%	
Хоёрдогч өглөг	76.0	1.6%	

Зах зээлд эзлэх хувь хэмжээ буюу нийт хөрөнгөд эзлэх хувиар нь харвал салбарын нийт хөрөнгийн

- o 25 хувийг нэр бүхий 4 ББСБ;
- o 50 хувийг нэр бүхий 16 ББСБ;
- o 75 хувийг нэр бүхий 87 ББСБ эзэлж байна.




	ББСБ–ын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь	Харилцагчдын тоо	
	Тоо	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%		Тоо	%
Топ 24 %	4	0.8%	1,177.1	25.2%	926.2	25.2%	1.2%	230,499	5.1%
Топ 50 %	16	3.0%	2,349.8	50.3%	1,923.6	52.3%	2.6%	3,837,417	84.6%
Топ 75 %	87	16.4%	3,506.4	75.0%	2,863.0	77.9%	4.7%	4,307,247	95.0%
САЛБАРЫН НИЙТ	529	100.0%	4,672.2	100.0%	3,675.8	100.0%	7.0%	4,535,672	100.0%

Банк бус санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн 25, 50 болон 75 хувийг бүрдүүлж буй ББСБ–уудын зээлийн үлдэгдэл салбарын нийт зээлийн үлдэгдлийн 25.2, 52.3, болон 77.9 хувийг тус тус эзэлж байна. Нийт хөрөнгө болон нийт зээлийн үлдэгдлийн эзлэх хувь ойролцоо хэдий ч нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь харгалзан 1.2, 2.6 болон 4.7 хувьтай байна.


Салбарын нийт хөрөнгийн 50 хувийг бүрдүүлж буй 16 ББСБ–уудын зарим нь үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг ашиглан, хүртээмжтэй байдлаар үйлчилгээ үзүүлдэг тул тус салбарын нийт үйлчлүүлэгчдийн 84.6 хувь нь эдгээр ББСБ–уудын харилцагчид юм.

	ББСБ–ын тоо	Нийт хөрөнгө		Нийт зээл		Харилцагчдын тоо	
		Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%
Дотоодын хөрөнгө оруулалт бүхий	505	3,936.4	84.3%	3,088.6	84.0%	4,433,003	97.7%
Гадаадын хөрөнгө оруулалт бүхий	24	735.8	15.7%	587.3	16.0%	102,669	2.3%


Гадаад хөрөнгө оруулалттай ББСБ–уудын 45.8 хувь буюу 11 нь Япон улсын, 25.0 хувь буюу 6 нь БНСУ–ын, 8.3 хувь буюу 2 нь АНУ–ын, үлдсэн нь БНХАУ, Сингапур, Их Британи, Малайз, Канад зэрэг бусад улсын хөрөнгө оруулалттай байна. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ–уудын хувьд салбарын нийт хөрөнгийн 15.7 хувийг эзэмшдэг бөгөөд нийт харилцагчдын 2.3 хувьд үйлчилгээ үзүүлдэг байна.



ББСБ–уудын нийт хөрөнгө Монгол Улсын ДНБ–ий 7.1 хувьтай тэнцэхүйц хэмжээнд байна.



Зээлийн хүү: ББСБ-уудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.3 хувьд хүрч өмнөх оноос 0.2 пунктээр өссөн.



НИЙТ ЗЭЭЛ

Салбарын хэмжээнд өмнөх онтой харьцуулахад 35.0 хувиар буюу 953.3 тэрбум төгрөгөөр, 2019 оноос 2.4 их наяд төгрөгөөр буюу 3.0 дахин өссөн дүнтэй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 97.4 хувийг төгрөгөөр, үлдсэн 2.6 хувийг валютаар олгосон зээл эзэлж байна.

97.4%



ХЭВИЙН

89.7%

+1.2%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

3.3%

-0.6%



ЧАНАРГҮЙ

7.0%

-0.6%

7,153.5 тэрбум төг | Олгосон зээл

Төлөгдсөн зээл | 6,179.0 тэрбум төг

Бөөний болон жижиглэн худалдаа



7.3%

7.3%

Барилга



3.4%

3.3%

Уул, уурхайн олборлолт



0.7%

0.7%

Машин, мотоциклийн засвар үйлчилгээ



1.9%

2.2%

Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээ



1.4%

1.3%

Боловсруулах үйлдвэр



0.6%

0.7%

Хөдөө аж, ахуй



0.5%

0.4%

Бусад



84.2%

84.1%



88.2%

90.6%

90.9%

ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ





11.8%

9.4%

9.1%



Нийт зээлийн үлдэгдлийн 88.2 хувь нь иргэнд, 11.8 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл байна.



ББСБ-ын салбарын олгосон зээлийг хугацаагаар нь эрэмбэлбэл 26.1 хувийг 1 сарын , 24.0 хувийг 6-12 сар хүртэлх, 17.6 хувийг 1-2.5 жилийн хугацаатай байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Улсын хэмжээнд 529 ББСБ болон тэдгээрийн 446 салбар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-ын байршлыг зураглалаар харуулбал дийлэнх буюу 82.0 хувь нь Улаанбаатар хотод байршиж байна.






Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн улс орнуудад санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг тооцвол:

21 аймгаас 12 аймагт 3 буюу түүнээс дээш тооны ББСБ ажиллаж байгаа нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй нийт ББСБ-ын 57.1 хувийг эзэлж байна.

1,000 хүн аж ахуй нэгжид ногдох



100,000 хүн амд ногдох



Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 428 ББСБ-ын 32.7 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 28.0 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 16.6 хувь нь Баянгол дүүрэгт, 10.8 хувь нь Баянзүрх дүүрэгт, 9.6 хувь нь Хан-Уул дүүрэгт, 2.1 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршиж байна.

ББСБ-УУДЫН ХҮРТЭЭМЖ, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР

- Монгол Улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 50 ББСБ, 1000 аж ахуйн нэгжид 10 ББСБ ногдож байна.
- Орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 26, 9 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд төвийн бүс 100,000 иргэнд 33, зүүн бүс 1000 аж ахуй нэгжид 12 ББСБ ногдож байгаагаар ББСБ-ын хүртээмжээр тэргүүлж байна.
- Улаанбаатар хотын хувьд 100,000 иргэнд 75, 1000 аж ахуйн нэгжид 10 ББСБ ногдож байгаа нь орон нутгаас хүртээмж сайтай байгааг харуулж байна.

Улсын хэмжээнд
100,000 хүнд

50
ББСБ

1,000 аж
ахуйн нэгжид


10
ББСБ




ДУНДАЖ ЗЭЭЛ

- ББСБ-аас нэг зээлдэгч авсан зээлийн хэмжээ дунджаар Монгол улсын хэмжээнд 2,296.8 мянган төгрөг бол орон нутагт энэхүү үзүүлэлт 1,867.9 мянган төгрөг, Улаанбаатар хотын хувьд 2,306.9 мянган төгрөг байна.
- Улсын хэмжээнд ББСБ-ын нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ өмнөх онтой харьцуулбал 4.26 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өсжээ.
- Зээлдэгчдийн тоо 1.6 сая байгаа нь давхардсан тоогоор хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 100 хүн тутмын 81 нь ББСБ-аас зээлтэй байна гэсэн үг юм.


ББСБ-ын харилцагчид



ББСБ-ын зээлдэгчид /насны бүлгээр/



ББСБ-ын зээлдэгчид /боловсролын түвшингээр/



ББСБ-ын ажилчид

Эрэгтэй
40.8%



Эмэгтэй
59.2%





БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ББСБ-ЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

- ББСБ–уудын нийт орлого 1,163.8 тэрбум төгрөгт хүрэв.
- Нийт орлогын 97.9 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Үүнээс нийт орлогын 85.9 хувь буюу 999.1 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 12.0 хувь нь буюу 140.0 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна.




ХҮҮГИЙН БУС ОРЛОГЫН ЗАДАРГАА

- Хүүгийн бус орлогын 70.7 хувийг санхүүгийн үйлчилгээний орлого, 15.3 хувийг арилжааны орлого, 14.0 хувийг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого бүрдүүлж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ


- Зардал 731.7 тэрбум төгрөгт хүрсэн. Уг зардалын 75.5 хувийг үндсэн үйл ажиллагааны зардал буюу хүүгийн болон хүүгийн бус зардал байгаагаас 56.4 хувь буюу 412.4 тэрбум төгрөгийг хүүгийн бус зардал, 19.1 хувь нь буюу 140.0 тэрбум төгрөгийг хүүгийн зардал болно.



Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлтэй холбоотой гарах зардал буюу болзошгүй эрсдэлийн зардалын хувьд нийт 93.5 тэрбум төгрөг ба үүний 93.8 хувийг зээлийн эрсдэлийн зардал, 3.2 хувийг авлагын эрсдэлийн зардал, 2.9 хувийг өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал, 0.1 хувийг факторинг үйлчилгээний эрсдэлийн зардал бүрдүүлж байна.


- Салбарын хэмжээнд нийт 14.7 тэрбум төгрөгийн факторингийн цэвэр авлага бүртгэлтэй байна.

Факторингийн үйлчилгээний цэвэр авлага /тэрбум төгрөг/




- Салбарын хэмжээнд 82 ББСБ итгэлцлийн үйлчилгээ эрхэлж байна.
- Тэдгээрийн үзүүлсэн итгэлцлийн үйлчилгээний нийт өглөг 651.9 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 71.0 хувиар өсжээ.

Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөг/



Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого /сая төгрөг/




- Салбарын хэмжээнд уг үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 46 ББСБ-аас 12 ББСБ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс 4.8 тэрбум төгрөгийн орлого олжээ. Энэ нь өмнөх оноос 2.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

ХУДАЛДСАН, ХУДАЛДАН АВСАН ВАЛЮТЫН МЭДЭЭ


ББСБ-ууд нийт 3,848.1 төгрөгийн валют худалдан авч, 3,785.7 тэрбум төгрөгийн валютыг худалдсан байна. Худалдаж авсан валютын 43.6 хувийг, худалдсан валютын 45.9 хувийг БНХАУ-ын юань бүрдүүлж байна.

ВАЛЮТЫН НЭР	Худалдаж авсан	Худалдсан
	Дүн /тэрбум төгрөг/	Дүн /тэрбум төгрөг/
БНХАУ-ЫН ЮАНЬ	1,678.6	1,737.9
АНУ-ЫН ДОЛЛАР	1,572.5	1,459.7
ЯПОНЫ ИЕН	214.7	206.9
ЕВРО	193.1	189.3
ОХУ-ЫН РУБЛЬ	117.1	118.6
БНСУ-ЫН ВОН	58.6	59.0
БУСАД	13.5	14.3


АШИГТ АЖИЛЛАГАА



	<1%	<5%	<10%	>10%
Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	21.7%*	17.6%	16.3%	44.4%
Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	22.3%	18.7%	18.5%	40.5%



ROE болон ROA-ийн харгалзах интервал дахь ББСБ-ын тоо /хувиар/
 (*) Жишээ нь: Нийт ББСБ-уудын 21.7 хувь нь 1.0 хувиас доош өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажиллаж байна



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦАА /ХӨРӨНГИЙН АНГИЛЛААР/

ББСБ-уудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хувь нийлүүлсэн хөрөнгийн ангиллаар харахад 1.0 тэрбум төгрөгөөс доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 7.1 хувиас бага, 1-2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 6.0 хувиас бага, 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 10.5 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 7.2, 6.6 болон 14.0 хувьтай байна.

ЗАРДАЛ, ОРЛОГЫН ХАРЬЦАА


ББСБ-ууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог харьцаа болох зардал, орлогын харьцаа 62.9 хувь гарсан буюу өмнөх онтой харьцуулахад 13.3 пунктээр өсжээ. Өөрөөр хэлбэл ББСБ-ууд 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 62.9 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм.



- ББСБ-ууд НДШ-д 28.7 тэрбум төгрөг, ХХОАТ-т 9.8 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 72.9 тэрбум төгрөгийг тус тус төлж, нийт 111.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


- o AFI-с санхүүгийн хүртээмж болон санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох зөвлөмж зааврын дагуу ББСБ-уудын дараах 4 үзүүлэлтийг тооцож байна. Үүнд:



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХАРЬЦАА


- o Уг харьцаа 107.6 хувь гарч байгуулвал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан бөгөөд эрсдэлийг 107.6 хувиар нөхөх чадамжтайг харуулжээ.
- o Энэ нь өмнөх оноос 2.2 пунктээр өссөн үзүүлэлт юм.

107.6%




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

Чанаргүй зээлийн хэмжээ 259.1 тэрбум төгрөгт хүрч нийт зээлд эзлэх хувь 7.0 хувь болжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 0.6 пунктээр буурсан үзүүлэлт юм.




МӨНГӨН ХӨРӨНГИЙГ НИЙТ ХӨРӨНГӨД ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦАА

- Уг харьцаа 14.0 хувь болж өмнөх оноос 0.1 пунктээр өссөн байна.



Z ИНДЕКС

Z индекс нь ББСБ-ын дампуурах магадлалыг харуулдаг ба нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг нийт хөрөнгийн өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. Банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оноос 5.9 пунктээр өсөж 21.2 боллоо.





94.1%

Финтек зээлдэгч

- Эдгээр ББСБ-аар тус салбарын нийт харилцагчдын 94.1 хувь, нийт зээлдэгчдийн 82.4 хувь зээлийн үйлчилгээг хүртжээ.
- Нийт зээлдэгчдийн 39.3 хувь нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авсан байна.
- Санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 91.0 хувийг хэвийн, 2.9 хувийг хугацаа хэтэрсэн, 6.1 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна.

	Нийт зээл		Зээлдэгчийн тоо		1 зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ /мян. төгрөг/
	Хэмжээ /тэрбум төгрөг/	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	
Финтек	758.5	20.6%	1,318,717	82.4%	575.2
Уламжлалт	2,917.4	79.4%	281,710	17.6%	10,355.9
НИЙТ	3,675.9	100.0%	1,600,427	100.0%	2,296.8



91.0%

Хэвийн


2.9%

Хугацаа хэтэрсэн зээл

6.1%


Чанаргүй

Зөвхөн технологид суурилсан



Зөвхөн технологид суурилсан зээл олгодог ББСБ-уудын хувьд салбарын нийт зээлийн үлдэгдэлд бага хувь эзэлж байгаа ч олгосон болон төлөгдсөн зээлийн харвал эргэлт сайн байна.


НОГООН ЗЭЭЛ



	КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	НОГООН БАРИЛГА	ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ
Ногоон зээл тус бүрийн эзлэх хувь	92.7%	4.5%	1.5%	0.5%	0.7%	0.1%
Зээлдэгчдийн тоо	10,463	743	98	14	42	23
Зээлийн үлдэгдлийн дүн /сая төг/	144,482.2	7,071.9	2,241.3	799.6	1,088.5	201.6

Олгосон зээл: 28 ББСБ нэр бүхий 6 төрлийн ногоон бүтээгдэхүүнд 142.0 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР



- 0-5 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр
- 5-10 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр
- 10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр

Олгосон зээл

	ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	НОГООН БАРИЛГА	ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ
Зээлдэгчдийн тоо	61	173	6	7,465	186	31
Зээлийн үлдэгдлийн дүн /сая төгрөг/	143.0	2,149.2	713.3	133,750.9	4,982.3	301.5

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагын салбарын бодлого зохицуулалтын чиглэлээр дараах олон улсын байгууллага, холбоодтой хамтран ажиллаж байна.

- Байгаль орчин нийгэм засаглалыг олон улсын стандартын дагуу нэвтрүүлэн, хэрэгжүүлж буй бизнесийн байгууллагууд, Сингапур улсын бодлого зохицуулагч байгууллагууд, Хөрөнгийн бирж, санхүүгийн болон хөрөнгө оруулагч байгууллагуудтай уулзалт зохион байгуулж Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох төлөөлөл болон ТОС холбоо 11 дүгээр сарын 18–25-ны өдрүүдэд өдрүүдэд оролцов.
- Ерөнхийлөгчийн Тамгын газраас санаачлан уур амьсгалын санхүүжилтийн арга хэрэгслүүд, стратеги, шаардлагатай эрх зүйн шинэчлэлийг тодорхойлох “Уур амьсгалын санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх нь”, “Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлэх бодлогын арга хэрэгслүүдийг практикт нэвтрүүлэх нь” сэдэвт цуврал бодлогын хэлэлцүүлгүүдэд 2023 оны 12 дугаар сарын 12, 19-ний өдрүүдэд Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох төлөөллүүд оролцон байр сууриа илэрхийлж, санал солилцов.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Азийн Хөгжлийн банкны төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Итгэлцлийн үйлчилгээний журам болон банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах түүнд хяналт тавих журмын хяналт шалгалт”-ын гарын авлагын талаарх хэлэлцүүлэг 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 10 цагт зохион байгуулсан.
- Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн салбарыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн санхүүжилтээр 2023 оны 10 дугаар сарын 22–ноос 25-ны өдрүүдэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудад “Зүүн бүсийн банк бус санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулах” сэдэвт сургалтыг зохион байгуулав.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.
 - “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ын нэмэлт өөрчлөлтийг, 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 434 дугаар тогтоолоор баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 434 дугаарт бүртгэсэн.
 - “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын нэмэлт өөрчлөлтийг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан А/226/528 дугаар тушаалаар баталсан.
 - Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцааг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 794 дүгээр тогтоолоор баталсан.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 92.3 хувь буюу 468 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 86.9 хувь буюу 441 ББСБ хэрэгжүүлсэн байна.

“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

- Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.
- Зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 478 ББСБ бүгд Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1–д “Энэ хуулийн 4.1–д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 130 ББСБ, 16,698 удаагийн тохиолдлоор, 3.4 тэрбум төгрөгийг, мөн зүйлийн 7.2–т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1–д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ” гэж заасны дагуу нэр бүхий 6 ББСБ, 158 удаагийн тохиолдлоор, 7.0 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА–нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн.

Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”–ын хэрэгжилт

- 2023 оны байдлаар нийт 497 ББСБ–аас 1,225.7 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 99.7% буюу 489 ББСБ 1,222.8 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө

306.5 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **14.5%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нийт салбар **61**

Нийт гишүүдийн

72,521



Хүртээмжтэй байдал

Нийт хадгаламж

215.2

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг

10.9

тэрбум төгрөг

Улсад татан
төвлөрүүлсэн
татвар, НДШ

3.7

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Нийт зээлд эзлэх чанаргүй
зээлийн хувь

3.2%

Мөнгөн хөрөнгийн нийт
хөрөнгөд эзлэх хувь

24.7%


Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ХЗХ–ДЫН ТОО БА ГИШҮҮД

- Үйл ажиллагаа эрхэлж буй Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)–дын тоог өмнөх онтой харьцуулахад 5–аар буюу 2.6 хувиар буурч 191 боллоо.
- ХЗХ–дын гишүүдийн тоо 2022 онд 71,657 байсан бол тайлант онд 1.2 хувиар өсөж 72,521–т хүрэв.
- ХЗХ–дын тоог 2019 онтой харьцуулбал 26.8 хувиар буурсан бол гишүүдийн тоо 2.2 хувиар өсжээ.



АЖИЛЛАГСАД

1,035

Өнгөрсөн оноос 35.8 хувиар өссөн ба 62.3 хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

НИЙТ ГИШҮҮДИЙН


29,515

ЗЭЭЛДЭГЧ

43,294

ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ

■ Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ ○ Нийт хөрөнгийн өсөлт /хувь/



НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Нийт хөрөнгө өмнөх оноос 14.5 хувиар өсөж 306.5 тэрбум төгрөгт хүрлээ.
- 2019 онтой харьцуулбал нийт хөрөнгийн дүн 83.9 тэрбум төгрөгөөр буюу 37.7 хувиар нэмэгдсэн.

НИЙТ ЗЭЭЛ

209.1

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ХАДГАЛАМЖ

215.2

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

Салбарын нийт хөрөнгийн

- 88.4 хувийг 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 33 ХЗХ;
- 4.9 хувийг 500 саяас 1 тэрбум төгрөг хүртэл хөрөнгөтэй 21 ХЗХ;
- 6.7 хувийг 500 сая төгрөгөөс доош хөрөнгөтэй 137 ХЗХ эзэлж байна.

88.4%

1.0 тэрбум төгрөгөөс дээш

33 ХЗХ

4.9%

500.0 сая төгрөгөөс доош

21 ХЗХ


500.0 саяас 1.0 тэрбум

6.7%

137 ХЗХ


Тайлангийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	306.5	100.0%
Эргэлтийн хөрөнгө	302.4	98.7%
Мөнгөн хөрөнгө	75.6	24.7%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	0.9	0.3%
Зээл /цэврээр/	204.2	66.6%
Авллага	17.2	5.6%
Бусад эргэлтийн хөрөнгө	3.6	1.2%
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	0.9	0.3%
Эргэлтийн бус хөрөнгө	4.1	1.3%
Үндсэн хөрөнгө /цэврээр/	4.0	1.3%
Биет бус хөрөнгө /цэврээр/	0.1	0.0%
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	306.5	100.0%
Өр төлбөр	237.0	77.3%
Хадгаламж	215.2	70.2%
Богино хугацаат зээл	2.3	0.7%
Бусад богино хугацаат өр төлбөр	18.4	6.0%
Урт хугацаат өр төлбөр	1.1	0.4%
Өөрийн хөрөнгө	69.5	22.7%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	27.5	9.0%
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.2	0.1%
Хоршоологчдын өмч	41.8	13.6%



- Нийт хөрөнгийн 98.7 хувь нь эргэлтийн хөрөнгө, үлдсэн 1.3 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.
- Эргэлтийн хөрөнгийн бүрдлийг нийт хөрөнгөд эзлэх хувиар задалбал 24.7 хувийг мөнгөн хөрөнгө, 66.6 хувийг цэвр зээлийн үлдэгдэл, 5.6 хувийг авлагын үлдэгдэл, 1.2 хувийг бусад хөрөнгө, 0.3 хувийг өмчлөх бусад хөрөнгө, 0.3 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.
- Эх үүсвэрийн хувьд нийт хөрөнгийн 77.3 хувийг өр төлбөр, 22.7 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



БАРУУН БҮС

40 ХЗХ

8 САЛБАР

ХАНГАЙН БҮС

18 ХЗХ

18 САЛБАР

ТӨВИЙН БҮС

21 ХЗХ

20 САЛБАР

ЗҮҮН БҮС

12 ХЗХ

11 САЛБАР

УЛААНБААТАР

100 ХЗХ

4 САЛБАР

- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 91 ХЗХ-дын 44.0 хувь нь баруун бүсэд, 23.1 хувь нь төвийн бүсэд, 19.7 хувь нь хангайн бүсэд, 13.2 хувь нь зүүн бүсэд байршжээ.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 100 ХЗХ-ны 96.0 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 4.0 хувь нь алслагдмал гурван дүүрэгт байршиж байна.




“Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)”-ийн улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг¹ ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 10,000 хүнд ногдох, 1,000 аж ахуйн нэгж (ААН)-д ногдох ХЗХ-дын тоогоор тооцоолоход дараах байдалтай байна.

10 000 хүнд ногдох ХЗХ-ны тоо



1 000 ААН-д ногдох ХЗХ-ны тоо




- 1,000 ААН-д ногдох ХЗХ-ны тоогоор Налайх дүүрэг 2.8, Багануур 4.4 үзүүлэлтэйгээр тус тус тэргүүлж байгаа бол Баянгол дүүрэг 0.7 гэсэн үзүүлэлтэйгээр хамгийн доогуур жагсаж байна.
- 10,000 хүнд ногдох ХЗХ-ны тоогоор Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүд тус тус 3.2, 2.4, 2.4 гэсэн үзүүлэлтээр тэргүүлж байна.

¹ <https://www.afi-global.org/sites/default/files/publications/fidwg-core-set-measuring-fi.pdf>

10 000 хүнд ногдох ХЗХ-ны тоо



1 000 ААН-д ногдох ХЗХ-ны тоо



Хүртээмжийн үзүүлэлтийг 4 бүсээр ангилахад баруун бүс 10,000 хүнд ногдох, 1,000 ААН-д ногдох ХЗХ-дын тоогоор бусад бүсээс илүү үзүүлэлттэй байна.

Нэг гишүүнд ногдож буй дундаж зээл



ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 66 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, зээлийн үйлчилгээ хүртжээ.
- Дээрх үзүүлэлт нь орон нутагт 63 хүн тутмын нэг бол Улаанбаатар хотын хэмжээнд 71 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг гишүүн дунджаар 7.1 сая төгрөгийн зээлтэй.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 11.8 сая төгрөг, орон нутагт 3.2 сая төгрөг байна.




ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 45 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, хадгаламжийн үйлчилгээг хүртсэн.
- Дээрх үзүүлэлт орон нутагт 50 хүнд нэг, Улаанбаатар хотын хэмжээнд 41 хүнд нэг тохиожээ.
- Улсын хэмжээнд ХЗХ-нд нэг хадгаламж эзэмшигч гишүүн дунджаар 5.0 сая төгрөгийн хадгаламжтай байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 7.4 сая төгрөг, орон нутагт 2.2 сая төгрөг байна.

Нэг гишүүнд ногдож буй хадгаламжийн дундаж хэмжээ




ХЗХ-НЫ ГИШҮҮДИЙН ХҮРТЭЭМЖ



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ХЗХ-ДЫН ЗЭЭЛ

- Зээлийн үлдэгдэл дүн 209.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 1.1 тэрбум төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан. 2019 онтой харьцуулбал 52.4 тэрбум төгрөгөөр буюу 33.4 хувиар нэмэгджээ.
- Цэвэр зээлийн хэмжээ өмнөх оноос 0.4 хувиар буурч 204.2 тэрбум төгрөгт хүрсэн бол, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 7.9 хувиар буурч 4.8 тэрбум төгрөг болсон.



ХЭВИЙН

92.7%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

4.1%



ЧАНАРГҮЙ

3.2%

ХЗХ-ДЫН ЗЭЭЛИЙН ЧАНАР

- Хэвийн зээлийн хэмжээ өмнөх оноос 1.7 хувиар буурч 193.9 тэрбум төгрөг буюу нийт зээлийн 92.7 хувийг эзэлж байна.
- Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оноос 43.7 хувиар өсөж 8.5 тэрбум төгрөгт, чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос 5.3 хувиар буурч 6.7 тэрбум төгрөгт тус тус хүрлээ.
- 2019 онтой харьцуулахад чанаргүй зээлийн дүн 0.5 тэрбум төгрөгөөр буюу 8.5 хувиар өсжээ.

ХЗХ-ДЫН ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

- Нийт зээлийн 16.6 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар, 12.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 17.5 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны зориулалтаар тус тус олгогдсон байна.
- Нийт эргэн төлөгдсөн зээлийн 17.8 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар, 11.8 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаа, 11.7 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаанд зориулж олгосон зээлээс тус тус төлөгджээ.

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ

Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл



17.8%

16.6%

Бөөний, жижиглэн худалдаа



11.8%

12.3%

Санхүүгийн, даатгалын үйл ажиллагаа



11.7%

17.5%

ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур



4.9%

5.1%

Машин мотоциклийн засвар үйлчилгээ



4.0%

4.2%

Барилга



2.8%

3.1%

Байр орон сууц, хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа



1.3%

1.9%

Боловсруулах үйлдвэр



0.4%

0.2%

Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа



0.4%

0.5%


Бусад



44.9%

38.6%

■ Нийт хадгаламж /тэрбум төгрөг/ ○ Хадгаламжийн өсөлт /хувь/



ХЗХ-ДЫН ХАДГАЛАМЖ

- ХЗХ-дын хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 14.8 хувиар өсөж 215.2 тэрбум төгрөг боллоо.
- 2019 онтой харьцуулбал 59.4 тэрбум төгрөгөөр буюу 38.1 хувиар нэмэгджээ.

НИЙТ ХАДГАЛАМЖ

- 97.4 хувийг хугацаатай хадгаламж, 2.6 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.



97.4%

ХУГАЦААТАЙ



2.6%

ХУГАЦААГҮЙ



189 ХЗХ



2 ХЗХ

- ХЗХ-дын 97.4 хувь буюу 189 ХЗХ нь 215.2 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн.
- Үлдсэн 2.6 хувь буюу 2 ХЗХ хадгаламж татаагүй байна.

ОРЛОГО

ХЗХ–дын хүүгийн орлого өнгөрсөн онтой харьцуулахад 9.5 хувиар өсөж 61.2 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнд:

- Зээлийн хүүгийн орлого 91.19 хувь буюу 55.9 тэрбум төгрөг;
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 8.0 хувь буюу 4.9 тэрбум төгрөг;
- Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 0.8 хувь буюу 435.7 сая төгрөг;
- Үнэт цаасны хүүгийн орлого 0.01 хувь буюу 8.1 сая төгрөг.



ЗАРДАЛ

ХЗХ–дын хүүгийн зардал өнгөрсөн онтой харьцуулахад 13.1 хувиар өсөж 34.2 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнд:



- Хадгаламжийн хүүгийн зардал 96.0 хувь буюу 32.9 тэрбум төгрөг;
- Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал 3.9 хувь буюу 1.3 тэрбум төгрөг;
- Бусад хүүгийн зардал 0.1 хувь буюу 39.9 сая төгрөг байна.



АШИГТ АЖИЛЛАГАА

ХЗХ-ДЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

- ХЗХ-ны салбар 64.6 тэрбум төгрөгийн орлого олж, 53.7 тэрбум төгрөг зарцуулж, 10.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.
- Цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос 2.7 пунктээр буурч 17.0 хувьд хүрчээ.



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ


- Татварын дараах цэвэр ашгаар тооцоолоход ХЗХ-дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх онтой харьцуулахад 0.7 пунктээр буурч 18.7 хувьд хүрлээ.
- Нийт хөрөнгийн өгөөж нь 0.7 пунктээр буурч 3.6 хувьд хүрчээ.




- ХЗХ-д нийгмийн даатгалын шимтгэлд 2.1 тэрбум төгрөг, ХАОАТ-т 0.5 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 1.1 тэрбум төгрөг тус тус улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оноос 2.7 пунктээр өсөж 29.3 хувьд хүрлээ.
- Цэвэр орлогыг нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц орлогын харьцаа нь өмнөх оноос 2.7 пунктээр буурч 17.0 хувь болжээ.




■ Үйл ажиллагааны зардал ■ Нийт орлого ○ Үйл ажиллагааны зардал / Нийт орлого



ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА


- ХЗХ-дын 100.0 төгрөгийн орлого тутамд 24.9 төгрөгийн үйл ажиллагааны зардал ногдож байна.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХЗХ нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн 4 үзүүлэлт /PEARLS аргачлал/-ийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;
2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт.




ХЗХ-ДЫН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

- Чанаргүй зээлийн дүн өнгөрсөн оноос 0.3 тэрбум төгрөгөөр буурч 6.7 тэрбум төгрөг боллоо.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оноос 0.2 хувиар буурч 3.2 хувьд хүрсэн. ХЗХ-дын мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр энэхүү үзүүлэлт 5 хувиас бага байх ёстой.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ


- Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өнгөрсөн оноос 0.7 пунктээр буурч 25.7 хувь болжээ.
- Эргэлзээтэй зээлийн хувьд өнгөрсөн оноос 10.2 пунктээр өсөж 31.9 хувьд хүрсэн бол муу зээл 9.5 пунктээр буурч 42.4 хувьд хүрсэн байна.




ХЗХ-ДЫН ХӨРВӨХ ЧАДВАР:

- ХЗХ-дын нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа 24.7 хувьд хүрэв.
- Богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт 68.5 хувь байна.

■ (БХХО+Нийт зээл)/Нийт хөрөнгө ■ Мөнгөн хөрөнгө/Нийт хөрөнгө



- Зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь
- Зээлийн эрсдэлийн сангийн нийт хөрөнгөд эзлэх хувь



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН

- ХЗХ-дын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь 2.3 хувь, харин нийт хөрөнгөд эзлэх хувь 1.6 хувь байна.

Харьцаа	Зохистой хувь	Жилийн эцэс
Бусдаас авсан зээл/Нийт зээл	<20%	1.6%
Нийт хадгаламж/Нийт хөрөнгө	20%–80%	70.2%
Цэвэр зээл/Нийт хөрөнгө	60%–85%	66.6%
Хоршоологчдын өмч/Нийт хөрөнгө	>5%	13.6%
Нөөцийн сан/Хоршоологчдын өмч	>3%	30.3%
Хадгаламж хамгааллын сан/Хоршоологчдын өмч	>5%	6.9%
Тогтворжилтын сан/Хоршоологчдын өмч	>5%	6.8%
Үйл ажиллагааны зардал/Нийт хөрөнгө	<15%	5.3%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Азийн Хөгжлийн Банктай хамтран ТА-6883 REG: “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төслийн хүрээнд хэрэгжүүлж, Хадгаламж, зээлийн хоршооны эмэгтэй гишүүдийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн ногоон санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгааг хийж гүйцэтгэсэн. Уг судалгааны үр дүн болон ХЗХ-дод ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх олон улсын туршлагыг нэвтрүүлэх боломжийн талаар 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан нийт хадгаламж зээлийн хоршоод, бодлого тодорхойлогч болон дэмжигч байгууллагын төлөөлөгчийг хамруулсан хэлэлцүүлэгт танилцуулсан.
- Азийн Хөгжлийн Банктай хамтран ТА-9654MON “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийг хадгаламж, зээлийн хоршооны зах зээлд 2019–2023 онд амжилттай хэрэгжүүлж хэрэгжүүлж дуусгалаа.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, дагалдах хууль, үзэл баримтлал, танилцуулга, тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг баримт бичгүүдийн төслийг эцэслэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны холбогдох гишүүдэд хүргүүлэв.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын 2.1.16-д заасны дагуу Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоотой хамтран эрх олгох сургалтыг зохион байгуулж, шаардлага хангасан оролцогчдод гэрчилгээ олгов.





ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Нийт хөрөнгө

299.1
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нэг батлан даалтын
дундаж хэмжээ

157.9
сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Ирүүлсэн
хүсэлтийн тоо

440

Зөвшөөрөгдсөн
хүсэлтийн тоо

355



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

11.0 тэрбум төгрөг

Нийт ашиг

5.3 тэрбум төгрөг

Тогтвортой байдал




Чанаргүй батлан
даалтын эзлэх хувь

6.4%



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 299.1 тэрбум төгрөг хүрч өмнөх оноос 15.7 хувиар буюу 40.5 тэрбум төгрөгөөр өссөн.



- Сангийн батлан даалтын үлдэгдэл 98.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 25.7 хувиар буюу 20.1 тэрбум төгрөгөөр өссөн.
- Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл өмнөх оноос 27.6 хувиар буюу 42.3 тэрбум төгрөгөөр өсч 195.8 тэрбум төгрөгт хүрлээ.




- 2023 онд 99.2 тэрбум төгрөгийн 314 зээлд 49.6 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь өмнөх онтой харьцуулбал тооны хувьд 7.8 дахин, дүнгийн хувьд 3.6 дахин өссөн үзүүлэлтэй.





ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

2023 оны зээлийн батлан даалтын хүртээмж




НИЙТ БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ





НЭГ БАТЛАН ДААЛТЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ

- Нэг зээлдэгчийн батлан даалтийн үлдэгдэл дунджаар Улаанбаатар хотод 370.5 сая төгрөг, орон нутагт 58.0 сая төгрөг, улсын хэмжээнд 154.5 сая төгрөг байна.
- Бүс нутгуудын хувьд Баруун бүсэд нэг зээлдэгчид олгосон зээлийн батлан даалтын дундаж үлдэгдэл хамгийн их буюу 128.3 сая төгрөг байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

	Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо	Эзлэх хувь
2020	128	72	56.3%
2021	334	244	73.0%
2022	75	42	56.0%
2023	440	355	80.7%


Батлан даалт гаргуулах 440 хүсэлт ирснээс 355 хүсэлт нь зөвшөөрөгдсөн байна. Үүнээс 314 хүсэлтийн зээлд батлан даалт олгосон бөгөөд ирүүлсэн хүсэлтийн тоо нь өмнөх оноос 5.9 дахин, зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо 8.5 дахин өссөн байна. Хүсэлтийн зөвшөөрлийн хувь 80.7 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 24.7 пунктээр өсжээ.



2023 онд олгосон зээлийн батлан даалтын 38.3 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 38.9 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 22.8 хувийг бусад салбар эзэлж байна.

- 2023 онд гаргасан батлан даалтын дундаж хугацаа 193.6 сар буюу 16.1 жил байна.
- Энэ үзүүлэлт нь өмнөх оноос 108.8 сар буюу 9.1 жилээр өссөн үзүүлэлт юм.

193.6
САР



2023 онд тус сангаас олгосон батлан даалтын 46.5 хувийг Капитрон банк, 22.7 хувийг Худалдаа хөгжлийн банк, 12.3 хувийг Хаан банк, 8.7 хувийг Төрийн банк, 5.3 хувийг Богд банк, 2.9 хувийг Хас банк, 1.6 хувийг Голомт банкнаас гаргасан зээл бүрдүүлж байна.

АШИГТ АЖИЛЛАГАА




Орлогын бүтэц



Зарлагын бүтэц





Нийт хөрөнгийн өгөөж



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Сангийн чанаргүй батлан даалтын үлдэгдэл 6.3 тэрбум төгрөгт хүрлээ.

Чанаргүй батлан даалтын үлдэгдэл /тэрбум төгрөг/



Батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалт 6.4 хувь болж өмнөх онтой харьцуулахад 8.6 пунктээр буурсан.

- Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 41.1 хувь нь боловсруулах үйлдвэр, 22.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 12.5 хувь нь аялал жуулчлалын салбарт, 6.8 хувь нь үл хөдлөх хөрөнгө түрээсийн бизнесийн үйл ажиллагаа, 5.0 хувь нь барилгын салбарт, 12.4 хувь нь бусад салбарт олгосон батлан даалтууд бүрдүүлж байна.





ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Зохицуулалттай этгээд

308



Салбарын төлөв

ҮХХ-ийг зуучлан худалдан,
шилжүүлжээ.

2,287.5
тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



98.7%

Улаанбаатар хотод үйл
ажиллагаа эрхлэгчид


Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ



Тус салбарт 308 ҮХЭХЗ-ын байгууллага тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж, өмнөх оноос 3-аар өссөн үзүүлэлттэй байна.



Брокерын тоо 321-д хүрч өмнөх оноос 2-оор буюу 0.6 хувиар өссөн бол агентын тоо 1,284-д хүрч өмнөх оноос 211-аар буюу 14.1 хувиар буурсан.

Брокер, агентуудын статистик мэдээлэл



Нэг ҮХЭХЗ-ын байгууллага дунджаар 1 брокер, 4 агенттай ажиллаж байна. Хамгийн олон агенттай ҮХЭХЗ-ын байгууллагад 75 агент ажиллаж байна.

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

ҮХЭХЗ-ын байгууллагуудын 465 хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6.7 тэрбум төгрөг байна.



НИЙТ ХӨРӨНГӨ


ҮХЭХЗ-ын байгууллагуудын нийт хөрөнгө 242.8 тэрбум төгрөг бөгөөд үүний 196.4 тэрбум төгрөг буюу 80.9 хувийг эргэлтийн хөрөнгө, үлдсэн 46.4 тэрбум төгрөг буюу 19.1 хувийг эргэлтийн бус хөрөнгө, эх үүсвэрийн 207.9 тэрбум төгрөг буюу 85.6 хувийг өр төлбөр, 34.9 тэрбум төгрөг буюу 14.4 хувийг эздийн өмч эзэлж байна.

ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН АНГИЛАЛ	Мөнгөн дүн / тэрбум төгрөг/	Хөрөнгө болон эх үүсвэрт эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	196.4	80.9%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	46.4	19.1%
ӨР ТӨЛБӨР	207.9	85.6%
ЭЗДИЙН ӨМЧ	34.9	14.4%

ҮХЭХЗ-ын байгууллагуудын нийт хөрөнгийн дүнгээр зах зээлд эзлэх хувийг тооцоход зах зээлийн 80.7 хувийг 11 компани бүрдүүлж байна.


Нийт хөрөнгийн дүнгээр зах зээлд эзлэх хувийг авч үзвэл 90 сая төгрөгөөс дээш хөрөнгөтэй 101 ҮХЭХЗ-ын байгууллагуудын зах зээлийн 58.1 хувийг, 60-с 90 сая төгрөг хүртэл хөрөнгөтэй 28 ҮХЭХЗ-ын байгууллагууд зах зээлийнхээ 9.1 хувийг, 60 сая төгрөг хүртэл хөрөнгөтэй 179 компаниуд зах зээлийнхээ 58.1 хувийг тус тус бүрдүүлж байна.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ




ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Гадаадын хөрөнгө оруулалт салбарын хэмжээнд 21.1 хувьд хүрч өмнөх оноос 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ҮХЭХЗ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БАЙРШИЛ:



1.3%

ОРОН НУТАГ 4



31.8%

СУХБААТАР 96

26.1%

ХАН-УУЛ 81

11.1%

ЧИНГЭЛТЭЙ 36

11.2%

БАЯНГОЛ 32

16.9%

БАЯНЗҮРХ 55

1.6%

СОНГИНОХАЙРХАН 4

ҮХЭХЗ-ын байгууллагуудын 31.2 хувь нь Сүхбаатар, 26.3 хувь нь Хан-Уул, 11.9 хувь нь Чингэлтэй, 17.6 хувь нь Баянзүрх, 10.4 хувь нь Баянгол, 1.3 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус үйл ажиллагаа эрхэлж байгаа бол орон нутагт 4 ҮХЭХЗ-ын байгууллага буюу 1.3 хувь нь үйл ажиллагаа эрхэлж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



ШИГТГЭЭ


Хуучин орон сууцны 1 метр квадрат талбайн дундаж үнэ 3.6 сая төгрөг, үүнээс Сүхбаатар дүүрэгт хамгийн өндөр буюу 4.3 сая төгрөг байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт хамгийн бага буюу 2.6 сая төгрөг байна.

Харин шинэ орон сууцны 1 метр квадрат талбайн дундаж үнэ 4.0 сая төгрөг, үүнээс Сүхбаатар дүүрэгт хамгийн өндөр буюу 4.3 сая төгрөг байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт хамгийн бага буюу 2.7 сая төгрөг байна.

Эх сурвалж: ҮСХ, 1212.тн

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ҮХЭХЗ-ЫН ТҮРЭЭС, ХӨЛСЛӨХ БОЛОН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН БОРЛУУЛАХ




ҮХЭХ түрээслэх, хөлслөхөд зуучилсан нийт үнийн дүнгийн 64.4 хувийг орон сууцны, 30.1 хувийг арилжааны, 5.0 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай, 0.5 хувийг газар тус тус эзэлж байна.

Худалдсан үл хөдлөх хөрөнгийн талбайн 47.3 хувийг газар, 47.2 хувийг орон сууц, 4.6 хувийг арилжааны, 0.9 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө эзэлж байна.


худалдсан үл хөдлөх хөрөнгийн арилжсан дүнгийн 86.7 хувийг орон сууц, 11.3 хувийг арилжааны, 1.6 хувийг газар, 0.4 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө эзэлж байна.

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

ҮХЭХЗ-ын байгууллага нийт 10,343 хэлцлээр, 1,622.9 мянган м.кв талбай, 2,287.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, шилжүүлжээ.



Үл хөдлөх хөрөнгийн худалдаа




- Талбайн хэмжээ /мянган м.кв/
- Мөнгөн дүн /тэрбум төгрөг/

Худалдан борлуулсан ҮХЭХ-ийн үнийн дүнгийн хувьд өнгөрсөн онтой харьцуулахад 34.1 хувиар өссөн байна. Харин талбайн хувьд /м.кв/ өнгөрсөн оноос 17.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ, ХӨЛСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

ҮХЭХЗ-ын байгууллага 7,430 хэлцлээр 600.0 мянган м.кв талбай, 178.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлжээ.


Хэлцлийн тоо



Талбайн хэмжээ /үнийн дүнгээр, тэрбум төгрөг/



Үл хөдлөх хөрөнгийн түрээс



- Талбайн хэмжээ /мянган м.кв/
- Мөнгөн дүн /тэрбум төгрөг/

Түрээсэлж, хөлсөлсөн ҮХЭХ-ийн үнийн дүнгийн хувьд өнгөрсөн онтой харьцуулахад 59.9 хувиар буурсан. Харин түрээсэлж, хөлсөлсөн талбайн хувьд 28.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ОСЗҮХЭХ–ийн 1 метр квадратын дундаж үнэ дүүргээр

Дүүрэг	Үнэ /мянган төгрөг/	
Налайх	1,124.4	Зуучлалын байгууллагуудаар дамжуулан худалдаж, худалдан авсан орон сууцны зориулалттай ҮХЭХ–ийн нэг метр квадратын дундаж үнийн мэдээллийг үзүүлэв.
Сонгинохайрхан	2,758.2	
Баянзүрх	3,068.0	
Баянгол	3,087.3	
Сүхбаатар	3,383.2	
Хан–Уул	3,438.3	
Чингэлтэй	3,560.3	

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

БОГИНО ХУГАЦААНЫ ХӨРВӨХ ЧАДВАР

Нийт ҮХЭХЗ–ын байгууллагаас 212 нь богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

УРТ ХУГАЦААНЫ ХӨРВӨХ ЧАДВАР

Урт хугацаат хөрвөх чадварын хувьд 31 ҮХЭХЗ–ын байгууллага байна. Тэдгээрийн өр төлбөр, хөрөнгийн харьцааг тооцож үзэхэд өр төлбөр нь нийт хөрөнгийн 50–аас бага хувийг эзэлж буй 15, 50–аас 100 хувийн хооронд эзэлж буй 6, 100–аас их 9 ҮХЭХЗ–ын байгууллага байна.

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 23–ны өдрийн 235 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”–ыг шинэчлэн баталлаа.
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын мэргэжлийн оролцогчдын “Ёс зүйн журам”–ын төслийг боловсруулсан бөгөөд мэргэжлийн холбоо болон ҮХЭХЗ–ын байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлэх хэлэлцүүлгийг зохион байгууллаа.
- ҮХЭХЗ–ын салбарын брокер, агентын мэргэжлийн стандартыг батлуулах хүсэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлснээр, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03–ны өдрийн 03 тоот тогтоолоор “Ажил мэргэжлийн стандарт”–д үл хөдлөх эд хөрөнгийн салбарын мэргэжилтэн болох брокер, агентын ажил мэргэжлийг хамруулан батлуулжээ.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын брокер, агентын мэргэжлийн стандартыг батлуулах тухай хүсэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлснээр, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 тоот тогтоолоор “Ажил мэргэжлийн стандарт”-д үл хөдлөх хөрөнгийн салбарын мэргэжилтэн болох брокер, агентын ажил мэргэжлийг хамруулан батлуулсан.
- Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх зорилгын дор Барилга хот байгуулалтын яамны хэрэгжүүлж буй “Орон сууцны мэдээллийн нэгдсэн портал” системд үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын тайлангийн мэдээний загварыг оруулж, хөгжүүлэлтэд хамтран ажилласан. Энэхүү систем нь туршилтын шатанд хэрэгжиж байгаа бөгөөд тус системээс Монгол Улсын үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой статистик мэдээллүүдийг холбогдох эрх бүхий байгууллагууд харах боломжтой болох юм.
- “Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо” ГҮТББ-ын удирдах зөвлөл, стратеги төлөвлөлтийн хороо, хуулийн хэлтэстэй нийт 5 удаагийн уулзалтыг зохион байгуулж, салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

Уулзалт хэлэлцүүлэг: “Реалторуудын дуу хоолой форум-2023” арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан болон АНУ-д төвтэй Үндэсний реалторуудын холбооны Ази номхон далайн бүсийн дэлхийн зохицуулагч, Монгол Японыг хариуцсан төлөөлөгч, Вашингтоны реалторуудын холбооны ерөнхийлөгч зэрэг гадаадын зочид төлөөлөгч нар оролцож, үл хөдлөх хөрөнгийн мэргэжилтнүүдийн олон улс дахь үл хөдлөх эд хөрөнгийн салбарт үзүүлж буй нөлөөлөл, боломжийн талаар санал солилцов.

- “Комплаенсын эрсдэлийг удирдахуй” нээлттэй хэлэлцүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо болон “Санхүүгийн боловсролын зангилаа” ГҮТББ-тай хамтран зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлэгт Барилга, хот байгуулалтын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн хэмт хэрэгтэй тэмцэх газар, Терроризмтой тэмцэх зөвлөл зэрэг холбогдох төрийн байгууллагууд болон арилжааны банкны төлөөлүүд, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагууд оролцож салбарын тулгамдаж буй асуудлаар санал солилцлоо.

Сургалт: “Үл хөдлөх хөрөнгө бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо” ГҮТББ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд “Сургалт зохион байгуулах гэрээ”-ний дагуу “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын мэргэжилтэнд эрх олгох сургалт”-ыг нийт 20 удаа зохион байгуулж, 1,183 оролцогчд хамрагдав. Салбарын санхүүгийн ажилтан болон удирдах ажилтнуудад зориулсан 12 удаагийн сургалтад 370 оролцогчийг хамруулсан.

Бусад: Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргийнхээ дагуу иргэд, олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэгчдийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын агент, брокероор үйлчлүүлэхийг уриалсан, таних тэмдэг бүхий QR кодтой зурагт хуудсыг хэвлүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны болон “Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо” ГҮТББ-ын цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлсэн. Мөн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбартай холбоотой танилцуулга видео, богино шторк, ФБ рийлс 3-ийг бэлтгэж, иргэд олон нийтэд хүргэхэд бэлэн боллоо.



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

Арилжаа эрхлэгчдийн тоо

52

Хуулийн этгээд



Салбарын төлөв

428

Иргэн

Худалдан авсан үнэт
металл

433.8

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



75.5%

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэгч

Бодлого зохицуулалт




САЛБАРЫН ТӨЛӨВ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО:

Санхүүгийн зохицуулах хороо 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож эхэлснээр нийт 52 хуулийн этгээд, 428 иргэн үйл ажиллагаа явуулж байна.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД

52



86

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА
ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

122



220

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР
ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

52 хуулийн этгээдийн 84 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 10.0 тэрбум төгрөг байна.


Тус салбарт арилжаа эрхлэгч иргэдийн 323 буюу 75.5 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 105 буюу 24.5 хувь нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

Улаанбаатар хотод

75.5%

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ /БАЙРШЛААР/



- Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид ихэвчлэн орон нутагт, харин үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчид голчлон Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Тухайлбал үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн 62.3 хувь нь орон нутагт, 37.7 хувь нь Улаанбаатар хотод байршиж байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

ӨМНӨГОВЬ 2
ДАРХАН-УУЛ 5
ГОВЬ-АЛТАЙ 2
ХЭНТИЙ 1
УВС 1
БАЯНХОНГОР 10
ОРХОН 1

Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

ХОВД 2
ДАРХАН-УУЛ 5
БАЯНХОНГОР 1

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч

БАЯНХОНГОР 13
СЭЛЭНГЭ 22
ТӨВ 14
ДАРХАН-УУЛ 10
ГОВЬ-АЛТАЙ 3
ӨМНӨГОВЬ 5
УВС 2
ДОРНОГОВЬ 1
ӨВӨРХАНГАЙ 1
ХОВД 4
ДОРНОД 1

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУДАЛДАЖ БОЛОН ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛ:

Нийт 3,223.7 кг үнэт металлыг 433.8 тэрбум төгрөгөөр худалдан авч, 3,337.1 кг үнэт металлыг 461.1 тэрбум төгрөгөөр борлуулсан нь өмнөх онд худалдан авсан үнэт металлын үнийн дүнгээс 38.1 хувиар, худалдсан үнэт металлын үнийн дүнгээс 31.3 хувиар тус тус буурсан байна.

ҮНЭТ МЕТАЛЛ ЭРХЛЭГЧИД БОЛОН ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖ ХООРОНДЫН АРИЛЖАА



ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН




**ХУДАЛДАЖ
АВСАН
ҮНИЙН ДҮН**
33.4 тэрбум төгрөг

**ХУДАЛДАЖ
БОРЛУУЛСАН
ҮНИЙН ДҮН**
20.8 тэрбум төгрөг


Нийт 33.4 тэрбум төгрөгийн үнэт эдлэл худалдан авч, 20.8 тэрбум төгрөгийн үнэт эдлэлийг борлуулсан байна.

ҮНЭТ МЕТАЛЛЫН БОРЛУУЛАЛТЫН ДҮН /ТЭРБУМ ТӨГРӨГ/



ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН АНГИЛАЛ	Мөнгөн дүн /тэрбум төгрөг/	Хөрөнгө болон эх үүсвэрт эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	52.1	81.3%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	12.0	18.7%
ӨР ТӨЛБӨР	36.3	56.6%
ЭЗДИЙН ӨМЧ	27.8	43.4%

АШИГТ АЖИЛЛАГАА



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталлаа.
- Тус журмаар арилжаа эрхлэгчдээс тайлан, мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнах, мөн эртний эдлэлийн арилжаа эрхлэгчид тухайлсан маягтын дагуу арилжааны мэдээг гаргах, үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч /ҮМҮЧЭТХЭАЭ/-д арилжаа хийсэн тухай бүр татварын цахим төлбөрийн баримтын системд мэдээллийг илгээх, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь үнэт металл олборлосон аймаг, сумын мэдээллийг ирүүлэх зэрэг зохицуулалтыг журамласан.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

- ҮМҮЧЭТХЭАЭ-дэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гарц шийдлийг хэлэлцэх, оролцогч байгууллагуудын ойлголтыг нэгтгэх зорилгоор нэр бүхий 4 төрийн байгууллага, (Монголбанк, Эрүүгийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Ашигт малтмал, газрын тосны газар) 3 мэргэжлийн холбоодын төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулав.
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Ажлын хэсгээс боловсруулсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэгт оролцож, санал солилцсон.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- ҮМҮЧЭТХЭАЭ–дийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 13–16–ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Mongolian jewelry and metal–2023” арга хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ҮМҮЧЭТХЭАЭ–ийн зохицуулалт, хууль, эрх зүйн орчны талаарх зөвлөгөө, мэдээллийг 500 орчим иргэн, хуулийн этгээдэд хүргэж ажилласан.
- Монгол улсад Стандарт, хэмжил зүйн салбар үүсэж хөгжсөний 100 жил, Сорьцын хяналтын газрын 60 жилийн ойг тохиолдуулан иргэд олон нийтэд санхүүгийн боловсролыг олгох, төрийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 28–ны өдөр зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”–т оролцож, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн.
- 2023 оны 08 дугаар сарын 25–ны өдөр зохион байгуулагдсан Швейцар улсын үнэт металл цэвэршүүлэх үйлдвэр Argor Heraeus SA–ийн комплаенс хариуцсан болон Монголбанк, Монголын арилжааны банкнуудын төлөөлөлтэй “Хариуцлагатай алт олборлолт болон Монголд алт олборлох үйл ажиллагаа, гарал үүслийн баталгаажуулалт” сэдэвт уулзалтад оролцож санал солилцов.
- ҮМҮЧЭТХЭАЭ–ийн мэргэжлийн холбоо болон “Санхүүгийн боловсролын зангилаа” ГҮТББ–тай хамтран ҮМҮЧЭТХЭАЭ–дийн арилжаа эрхлэгчдийн 10 гаруй төлөөллүүдэд “Комплаенс–мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах” сэдэвт хэлэлцүүлгийг 2023 оны 01 дүгээр сарын 17–ны өдөр зохион байгуулсан.
- ҮМҮЧЭТХЭАЭ–дийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль бус уул уурхайн эрх зүйн зохицуулалтын талаар Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон холбогдох нэр бүхий төрийн байгууллагууд, Азийн сангийн хамтарсан уулзалтад оролцож, санал солилцсон.
- Сургалт ҮМҮЧЭТХЭАЭ–ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 198 иргэнд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 05 дугаар сарын 15–ны өдрийн 11/2011 тоот тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлэх ажлын хүрээнд 67 иргэнд 3 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан.
- Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2023 оны 12 дугаар сарын 01–ний өдрийн А/74 тоот тушаалын дагуу ҮМҮЧЭТХЭАЭ–дэд зориулсан сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад ҮМҮЧЭТХЭАЭ–ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 69 иргэн, 31 хуулийн этгээдийн төлөөлөл хамрагдсан.
- “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд эрх олгох сургалт”–ыг 2023 онд 3 удаа зохион байгуулж, 92 оролцогчдыг хамруулсан.

Бусад ажил: Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргийнхээ дагуу иргэд, олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэгчдийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай зөвшөөрөлтэй ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээд, иргэнээр үйлчлүүлэхийг уриалсан, таних тэмдэг бүхий QR кодтой гэмт хэрэг зөрчил, цахим залилангаас урьдчилан сэргийлэх тухай зурагт хуудсыг тус тус хэвлүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсаар олон нийтэд мэдээлж, “Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоо” ГҮТББ–д хүргүүлсэн. Мөн ҮМҮЧЭТХЭАЭ–ийн салбартай холбоотой танилцуулга видео 1, богино шторк 1, ФБ рийлс 2–ийг бэлтгэж, иргэд олон нийтэд хүргэхэд бэлэн болсон.



СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Хүсэлтийн тоо **19**



Салбарын төлөв

Туршигдаж буй
бүтээгдэхүүн **6**

972

удаагийн хэлцлээр



Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ

179.7

тэрбум төгрөгийн арилжаа

Р2Р зээлийн үйлчилгээ



5,485

Харилцагчид

1.7

тэрбум төгрөгийн
арилжаа

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ



331

Хөрөнгө
оруулагчид

44.7

сая төгрөгийн санхүүжилт

Инсуртекийн үйлчилгээ



315

Даатгуулагч

15

төрлийн даатгалын үйлчилгээ

СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Сэндбоксад ирүүлсэн хүсэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр

Сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших нийт 19 хүсэлт ирсэн бөгөөд эдгээрээс 8 бүтээгдэхүүн, үйлчилгээг Сэндбоксын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 7 бүтээгдэхүүн сэндбоксын орчинд орсон.



Инсуртекийн үйлчилгээ



Инсуртекийн үйлчилгээ нь 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр сэндбоксын орчинд орсон ба тус үйлчилгээ нь хэрэглэгч өөрийн хэрэгцээ шаардлага, эрсдэлд нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг ямар нэгэн зуучлагчгүйгээр өөрөө сонгон хэрэглэх, мөн эрсдэлд суурилсан газрын зураглалыг хөгжүүлж, даатгалын эрсдэлийг үнэлэх давуу талтай.



1,606
Бүртгэлтэй
харилцагч

315 даатгуулагч

5 хэлбэр
15 төрөл



Инсуртекийн үйлчилгээний платформд бүртгэлтэй 1,606 харилцагч байна. Тус платформ нь смарт төхөөрөмж, жолоочийн хариуцлага, эрүүл мэнд, гэнэтийн ослын зэрэг 5 хэлбэр, 15 төрлийн даатгалын үйлчилгээг 315 даатгуулагчид хүргэсэн.

Смарт төхөөрөмжийн
даатгал



0.1%

Авто тээврийн
даатгал



1.1%

Жолоочийн хариуцлагын
даатгал



12.5%

Эрүүл мэндийн
даатгал



86.3%

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ



Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ нь 2021.12.17–ны өдөр сэндбокс орчинд орсон бөгөөд 2022 онд Сэндбокс зохицуулалтын орчинд үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах хүсэлтийг гаргаж тус хүсэлтийн дагуу 2022.12.30–ны өдрийн 05 дугаар зөвлөмж, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 557 дугаар тушаалаар сэндбоксын хугацааг сунган мөнгөний захад хадгаламжийн сертификат, арилжааны бичиг, факторинг (хямдруулсан нэхэмжлэл), итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлэх төлбөр тооцоо, бүртгэл, хадгалалтын нэгдсэн платформыг хөгжүүлж 2 дахь жилдээ туршиж байна.

Хадгаламжийн сертификат

2023 оны 9 дүгээр сараас эхлэн Хадгаламжийн сертификат арилжаалагдаж эхэлсэн

Арилжааны дүн 52.5 сая төгрөг

Итгэлцэл

2023 оны 10 дугаар сараас итгэлцлийн арилжаа 6 болон 12 сарын хугацаатайгаар арилжаалагдаж эхэлсэн.

Арилжааны дүн 200.0 сая төгрөг



Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ нь өнгөрсөн хугацаанд репо хэлцэл зуучлалын платформ дээр 35 зээлдүүлэгч, 31 зээлдэгч оролцон нийт 179.7 тэрбум төгрөгийн 972 удаагийн арилжаа хийсэн байна.



Репо зээлийн дундаж хугацаа

34 хоног



Репо зээлийн дундаж хүү

17.8%

P2P зээлийн үйлчилгээ



P2P зээлийн үйлчилгээ нь 2022.12.30-ны өдөр Сэндбоксын орчинд орсон бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг зээлийн үнэлгээ, бүртгэлдээ ашиглан хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбох үйлчилгээ юм.



98.8%
зээлдэгч



1.2%
хөрөнгө оруулагч

Тус платформоор 5485 харилцагч P2P зээлийн үйлчилгээг хүртсэн. Эдгээр харилцагчдын 1.2 хувь нь хөрөнгө оруулагч, үлдсэн 98.8 хувь нь зээлдэгч байна.

P2P зээлийн үйлчилгээний нийт харилцагчдын тоо



- Платформоор нийт 1.7 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд үүнээс 759.3 сая төгрөгийн зээл нь эргэн төлөгдөж P2P нийт зээлийн үлдэгдэл 941.3 сая төгрөг байна.
- Харин тус платформоор дамжсан хөрөнгө оруулалтын багцын 42.1 хувийг 1 жилийн хугацаатай, 57.9 хувийг 1 жилээс бага хугацаатай хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.



3-9 сарын хугацаатай

Олгосон зээлийн дүн

1.7 тэрбум төгрөг

941.3
сая төгрөг
Зээлийн үлдэгдэл



Зээлийн ЖДХ 2.0%



Хэвийн
98.2%




Хугацаа хэтэрсэн
1.3%





Чанаргүй
0.5%

P2P платформоор зуучлагдан олгогдсон нийт зээлийн үлдэгдлийн 98.2 хувь нь хэвийн, 1.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 0.5 хувь нь чанаргүй гэсэн тус тус ангилалтай байна. Мөн P2P зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 2.0 хувьтай байна.



P2P зээлийн үйлчилгээний нийт харилцагчдын 65.2 хувь нь эмэгтэй, 34.8 хувь нь эрэгтэй харилцагчид байна. Харин нийт харилцагчдын 54.1 хувийг 18–35 насныхан, 32.4 хувийг 36–45 насныхан, 11.2 хувийг 46–55 насныхан, 2.3 хувийг 55–аас дээш насныхан тус тус бүрдүүлж байна. Харилцагчдыг боловсролын түвшнээр ангилбал 62.3 хувь нь дээд, 4.1 хувь нь тусгай дунд, 27.8 хувь нь бүрэн дунд, 4.4 хувь нь дунд, 1.4 хувь нь бага боловсролтой байна.



Хамтын санхүүжилтийн үйлчилгээ



Хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь 2022.12.30-ны өдрөөс эхлэн сэндбоксын орчинд орж хамтын санхүүжилтийн үйлчилгээ буюу краудфандинг үйлчилгээгээ туршиж байна. Одоогоор тус байгууллага нь урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг сэндбоксын орчинд туршиж байгаа бол зээл, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна.



Төслийн дундаж хугацаа 17 хоног



2023 онд урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн 8 төсөлд 291 хөрөнгө оруулагчаас нийт 44.7 сая төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлсэн.

Платформоор санхүүжилт босгосон эдгээр 8 төслийн 7 төсөл нь 1 сараас бага хугацаатай төслүүд бөгөөд төслийн дундаж хугацаа 15 хоног байна.

Хандивт суурилсан хамтын санхүүжилтийн 6 төсөл нийтлэгдсэн бөгөөд нийт 195 хүнээс 8.9 сая төгрөгийг босгосон.

Зээлд суурилсан 1 төсөл хэрэгжиж 2 хөрөнгө оруулагчаас 11.0 сая төгрөгийн санхүүжилт босгосон.



Платформоор дамжуулсан урамшуулалт санхүүжилтийн төслүүдэд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын 76.3 хувь нь 18–35 нас, 18.9 хувь нь 36–45 нас, 4.1 хувь нь 46–55 нас, 0.7 хувь нь 55–аас дээш насныхан байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД НАСНЫ БҮЛГЭЭР

18–35 НАС



76.3%

36–45 НАС



18.9%

46–55 НАС



4.1%

55–ААС ДЭЭШ



0.7%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Хууль, эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 190/71/А-72 дугаар хамтарсан тушаалаар “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг шинэчлэн баталсан.

Сэндбоксын орчны оролцогчдод хяналт тавих ажлын хүрээнд:

Сэндбокс орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтэй нийт 18 компанитай 56 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.

Оролцогчдоос ирсэн тайлан мэдээнд суурилан зайны хяналтыг тогтмол гүйцэтгэн, газар дээрх хяналт, үзлэгийг гүйцэтгэн ажиллаж байна.



Сэндбоксад туршигдаж буй бүтээгдэхүүний талаар холбогдох мэдээ, тайлан боловсруулан 7 хоног, сар, улирлаар авч мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

Сэндбоксад туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улс дахь хөгжил, зохицуулалтын орчны судалгааг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.

Хамтран ажиллах хүрээндд

Технологид суурилсан санхүүгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах “Финтек зохицуулалтын инновац хаб” байгуулах суурь судалгааг боловсруулан, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй техник туслалцааны хүрээнд Монгол Улсын “Финтек зах зээлийн экосистемийг хөгжүүлэх” чиглэлд төслийг хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Сэндбоксын орчныг олон нийтэд таниулах ажлын хүрээнд

Ухаалаг, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн салбарыг хөгжүүлэх технологийн дэвшил, инновацыг ашиглах хүрээнд “Санхүүгийн инновац текспринт” уралдааныг “Unread Media” – тай хамтран зохион байгуулсан.



Сэндбокс зохицуулалтын орчин гарын авлагатай болсон.



ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Виртуал хөрөнгийн
үйлчилгээ үзүүлэгч

12



Салбарын төлөв

Дотоодын виртуал
хөрөнгийн зах
зээлийн үнэлгээ

241.9 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



Харилцагчийн тоо


921,022

Бодлого зохицуулалт





САЛБАРЫН ТӨЛӨВ

Тус зах зээл дээр 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ) үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээрээс нэр бүхий 10 нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтад заасан 5 үйлчилгээ, нэр бүхий 2 ВХҮҮ нь мөн хуулийн 6.1.1, 6.1.3, 6.1.4 дэх хэсэгт заасан 3 үйлчилгээ үзүүлэхээр Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн.




Давхардсан тоогоор 921,022 харилцагч дээр дурдсан ВХҮҮ-д бүртгэлтэй байна. Үүнээс 1.6 хувь нь арилжаанд идэвхтэй оролцдог харилцагчид болно.




Дотоодын 49 виртуал хөрөнгө арилжаалагдаж байгаа нь нэгдүгээр улирлаас 19.5 хувь өссөн үзүүлэлт юм.

Нийт хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/

Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 20.1 хувиар буурч 55.7 тэрбум төгрөгт хүрэв.




Дотоод виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 241.9 тэрбум төгрөг болж өмнөх улирлаас 15.9 хувиар буурсан.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/

ВХҮҮ–дийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх онтой харьцуулбал 8.7 хувиар өслөө.



Дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн

136.6

Тэрбум төгрөг

Өдрийн дундаж АРИЛЖАА

150.1

Сая төгрөг

Дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн 136.6 тэрбум төгрөгт, өдрийн дундаж арилжааны дүн 150.1 сая төгрөгт хүрэв.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 253 дугаар тогтоолоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-ын нэмэлт өөрчлөлтийг баталлаа.

Энэхүү журмын гуравдугаар хавсралтад заасны дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь MNS ISO/IEC 27001–ээс бусад стандартыг үйл ажиллагаандаа мөрдөнө.

Харин MNS ISO/IEC 27001 мэдээлэл технологийн стандартыг хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байх үүрэг хүлээсэн.



ХАМТЫН АЖИЛЛАГАА


- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 59 дүгээр тушаалаар төрийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд бүргэлтэй, бүртгэлгүй виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн үнэлгээ тайлан дүгнэлт боловсруулсан.
- Санхүүгийн зохицуулах хороо “Монголын биржүүдийн нэгдсэн холбоо” ГҮТББ–тай хамтран Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдал, дотоод хяналт, МУТСТ шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргалаа.







ХАВСРАЛТ



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2021	2022	2023
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	5,982.9	6,890.4	11,650.2
ЗЗҮ/ДНБ	15.3%	14.0%	17.8%
Хөрвөх чадвар	3.8%	2.4%	1.5%
Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	304.9	343.4	524.8
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/	1,048.2	134.1	138.1
ХБҮЦ–ны арилжаа /тэрбум төгрөг/	4.2	69.7	63.5
Хөрөнгө оруулалтын сан /тэрбум төгрөг/	56.8	13.6	60.8
ТОП–20 индекс	44,411.60	37,565.55	41,437.42
MSE А индекс	15,482.77	14,137.94	17,574.53
MSE Б индекс	12,202.56	12,667.44	11,327.14
ХК–ийн тоо	314	318	310
ҮЦК–ийн тоо	55	52	52
ХАА–н биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	792.7	1,110.0	968.3

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2021	2022	2023
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	425.4	474.9	550.2
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж /тэрбум төгрөг/	247.5	304.8	398.7
Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	68.9	94.2	120.9
Нөөц сан /тэрбум төгрөг/	193.7	216.9	268.9
Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/	84.4	100.0	141.6
Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	25.2	18.5	11.8
Мэргэжлийн оролцогчид:			
Ердийн даатгал	15	15	15
Урт хугацааны даатгал	1	2	2
Давхар даатгал	1	1	1
Даатгалын төлөөлөгч	2,403	2,376	2,416
Даатгалын зуучлагч	57	63	63
Хохирол үнэлэгч	25	25	24
Актуарч	36	40	40
Аудитор	144	137	147
Аудитын компани	44	40	45

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2021	2022	2023
Нийт хөрөнгө	2,709.9	3,527.0	4,672.2
Эргэлтийн хөрөнгө	2,616.5	3,415.8	4,526.2
Мөнгөн хөрөнгө	429.7	490.5	652.9
Богино хугацаат хөрөнгө оруулалт	22.6	29.1	50.7
Нийт зээл	2,012.2	2,722.6	3,675.9
Хэвийн зээл	1,821.9	2,409.1	3,297.4
Хугацаа хэтэрсэн зээл	50.0	106.5	119.4
Чанаргүй зээл	140.2	207.0	259.1
Зээлийн эрсдэлийн сан	114.7	151.4	199.9
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	13.6	24.2	25.9
Эргэлтийн бус хөрөнгө	93.5	111.2	146.1
Нийт өр төлбөр	910.8	1,335.4	1,926.9
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	246.9	381.1	651.9
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	282.9	396.8	586.4
Төслийн зээлийн санхүүжилт	19.9	30.0	23.8
Эзэмшигчдийн өмч	1,799.1	2,191.6	2,745.3
Хоёрдогч өглөг	70.2	76.0	76.0
Хувьцаат капитал	1,114.1	1,275.7	1,498.0
Хуримтлагдсан ашиг	563.3	774.8	1,107.2
ББСБ-ын тоо	534	513	529
УБ хот	451	420	434
Хөдөө, орон нутаг	83	93	95
Харилцагчдын тоо	4,820,624	4,633,616	4,535,672
Нийт орлого	521.3	867.8	1,163.8
Хүүгийн орлого	421.7	701.9	999.1
Хүүгийн бус орлого	87.0	149.9	140.0
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	12.5	15.8	24.5
Нийт зардал	311.3	554.9	731.7
Хүүгийн зардал	48.0	95.6	140.0
Хүүгийн бус зардал	193.5	335.2	412.4
Болзошгүй эрсдэлийн зардал	37.3	69.1	93.5
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	6.7	8.2	179.3
Орлогын албан татварын зардал	25.8	46.8	72.9
Цэвэр ашиг	210.0	312.9	432.1

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021	2022	2023
Нийт хөрөнгө	291.2	267.7	306.5
Эргэлтийн хөрөнгө	280.1	263.6	302.4
Мөнгөн хөрөнгө	61.3	40.0	75.6
Авлага	9.1	15.8	17.2
Эргэлтийн бус хөрөнгө	11.1	4.1	4.0
Үндсэн хөрөнгө /цэврээр/	3.9	3.9	3.9
Биет бус хөрөнгө	7.2	0.2	0.1
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0	0.0
Нийт зээл	213.4	210.2	209.1
Хэвийн зээл	202.1	197.2	193.9
Хугацаа хэтэрсэн зээл	3.9	5.9	8.5
Чанаргүй зээл	7.4	7.0	6.7
Өр төлбөр	227.3	207.9	237.0
Хадгаламж	203.6	187.5	215.2
Богино хугацаат зээл	6.4	2.6	2.3
Урт хугацаат өр төлбөр	2.2	3.1	1.1
Бусад богино хугацаат өр төлбөр	15.1	14.7	18.4
Өөрийн хөрөнгө	63.9	59.8	69.5
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	25.4	25.9	27.5
Хоршоологчдын өмч	38.4	33.7	41.8
Хуримтлагдсан орлого /алдагдал/	21.8	14.7	20.0
Нийт орлого	58.0	58.9	64.6
Хүүгийн орлого	54.2	55.9	61.2
Үйл ажиллагааны бусад орлого	1.3	0.9	1.2
Үйл ажиллагааны бус орлого	2.5	2.1	2.2
Нийт зарлага	47.2	47.3	53.7
Хүүгийн зардал	31.9	30.2	34.2
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	2.0	1.6	2.2
Үйл ажиллагааны зардал	12.2	14.2	16.1
Үйл ажиллагааны бус зардал	0.3	0.1	0.1
Цэвэр орлого	10.7	11.6	10.9
ХЗХ-дын тоо	209	196	191
УБ ХЗХ-дын тоо	116	107	100
Орон нутаг ХЗХ-дын тоо	93	89	91
Гишүүдийн тоо /мянга/	75.400	71,657	72,521

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021	2022	2023
Нийт хөрөнгө	255.1	258.6	299.1
Батлан даалтын үлдэгдэл	85.4	78.1	98.2
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	1.3	4.2	1.8
Чанаргүй	11.3	11.7	6.3
Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл	167.1	153.5	195.8
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	2.8	7.4	2.1
Чанаргүй	24.3	24.6	19.3
Үндсэн үйл ажиллагааны орлого	10.6	12.2	11.0
Үндсэн үйл ажиллагааны зардал	2.6	3.6	6.1
Үндсэн үйл ажиллагааны үр дүн	8.0	8.6	4.9
Олгосон батлан даалтын тоо	241	40	314
Олгосон батлан даалтын дүн	33.7	13.7	49.6
Үүнээс: Хөдөө аж ахуй	0.6	0.3	0.5
Үйлдвэрлэл	6.5	5.4	19.0
Бөөний болон жижиглэн худалдаа	19.7	3.1	19.2
Үйлчилгээ	6.9	4.9	10.9
Батлан даалт гаргасан дундаж хугацаа /сараар/	43.8	84.8	193.6
Батлан даалт авахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	334	75	440
Үүнээс: Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	244	42	355

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2022	2023
ҮХЭХЗ–ын байгууллагын тоо	305	308
Брокерын тоо	319	321
Агентын тоо	1,495	1,284
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн талбайн хэмжээ /мянган м.кв/	1,971.5	1,622.9
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн үнэ / тэрбум ₮/	1,705.3	2,287.5
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлслөсөн ҮХХ–ийн талбайн хэмжээ / мянган м.кв/	840.2	600.0
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлслөсөн ҮХХ–ийн үнэ / тэрбум ₮/	444.1	178.1

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2022	2023
Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо	47	52
Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо	70	86
Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн тоо	255	220
Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн тоо	140	122
Худалдан авсан үнэт металлын бохир жин /кг/	8,490.8	3,223.7
Худалдан авсан үнэт металлын нийт үнэ / тэрбум ₮/	700.8	433.8
Худалдсан үнэт металлын бохир жин /кг/	8,325.3	3,337.1
Худалдсан үнэт металлын нийт үнэ /тэрбум ₮/	670.8	461.1
Худалдан авсан эдлэлийн нийт үнэ / тэрбум ₮/	–	33.4
Худалдсан эдлэлийн нийт үнэ / тэрбум ₮/	14.7	20.8

